

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/**

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	1
1 дүгээр зүйл. Хуулийн зорилго	1
2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж	1
3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	1
4 дүгээр зүйл. Хууль үйлчлэх хүрээ	3
5 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны зарчим	4
6 дугаар зүйл. Ерөнхий шаардлага	4
7 дугаар зүйл. Түншлэл, туслан гүйцэтгэгч	5
8 дугаар зүйл. Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, давуу эрх олгох	5
ХОЁРДУГААР БҮЛЭГ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ БЭЛТГЭХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ	6
9 дүгээр зүйл. Тендер шалгаруулалтын аргыг сонгох	6
10 дугаар зүйл. Тендер шалгаруулалтын баримт бичиг	7
11 дүгээр зүйл. Техникийн тодорхойлолт	7
12 дугаар зүйл. Техникийн тодорхойлолтод нийцэхийг нотлох баримт бичиг, дээж ирүүлэх	8
13 дугаар зүйл. Тендерийн баталгаа	8
14 дүгээр зүйл. Оролцогчийн чадавхын шаардлага	10
15 дугаар зүйл. Санхүүгийн чадавхын шаардлага	10
16 дугаар зүйл. Техникийн чадавх болон туршлагын шаардлага	11
17 дугаар зүйл. Тендер шалгаруулалтын зарлал	12
18 дугаар зүйл. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах	12
19 дүгээр зүйл. Тендер ирүүлэх болон хүчинтэй байх хугацаа	12
20 дугаар зүйл. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	13
21 дүгээр зүйл. Тендер бэлтгэх	13
22 дугаар зүйл. Тендер баталгаажуулж ирүүлэх, тендерийг хүлээн авах	14
ГУРАВДУГААР БҮЛЭГ ТЕНДЕР ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	14
23 дугаар зүйл. Тендер нээх	14
24 дүгээр зүйл. Тендер хянан үзэх, үнэлэх хугацаа	15
25 дугаар зүйл. Тендерийн талаар тайлбар, тодруулга авах	15
26 дугаар зүйл. Тендерийн нууцлал	15
27 дугаар зүйл. Тендер хянан үзэх	16
28 дугаар зүйл. Хэт бага үнэтэй тендер	17
29 дүгээр зүйл. Тендер үнэлэх	17

30 дугаар зүйл. Захиалагч шийдвэр гаргах, түүнийг танилцуулах	19
31 дүгээр зүйл. Гэрээнд гарын үсэг зурах.....	19
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА	19
32 дугаар зүйл. Тендер шалгаруулалтын арга	20
33 дугаар зүйл. Нээлттэй тендер шалгаруулалтын арга.....	20
34 дүгээр зүйл. Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулах.....	20
35 дугаар зүйл. Өрсөлдөөнт хэлэлцээний арга.....	21
36 дугаар зүйл. Үнийн санал цахимаар дуудах арга	21
37 дугаар зүйл. Нэг эх үүсвэрээс худалдан авах арга.....	22
38 дугаар зүйл. Ерөнхий гэрээ байгуулах арга.....	23
ТАВДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ	24
39 дүгээр зүйл. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ.....	24
40 дүгээр зүйл. Гэрээний үүргийг туслан гүйцэтгүүлэх.....	25
41 дүгээр зүйл. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглох.....	25
42 дугаар зүйл. Хүчин төгөлдөр бус гэрээ	26
43 дугаар зүйл. Гүйцэтгэлийн баталгаа.....	26
44 дүгээр зүйл. Урьдчилгаа төлбөр, түүний баталгаа	27
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА.....	27
45 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааг төлөвлөх.....	28
46 дугаар зүйл. Худалдан авах ажиллагаа зохион байгуулах	29
47 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааг тайлагнах	30
48 дугаар зүйл. Тендер шалгаруулалтыг хамтран зохион байгуулах	30
49 дүгээр зүйл. Захиалагчийн эрх, үүрэг.....	30
50 дугаар зүйл. Үнэлгээний хороо.....	31
51 дүгээр зүйл. Үнэлгээний хорооны хурал.....	32
52 дугаар зүйл. Худалдан авах ажиллагаанд оролцох ажилтан, албан тушаалтны үүрэг 33	33
53 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан.....	34
54 дүгээр зүйл. Бүртгэлийн тогтолцоо.....	34
55 дугаар зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	35
56 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны улсын байцаагч.....	36
57 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага	37
ДОЛООДУГААР БҮЛЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ.....	38
58 дугаар зүйл. Захиалагчид гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх	38
59 дүгээр зүйл. Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх зөвлөл.....	39
60 дугаар зүйл. Захиалагчийн шийдвэрт гомдол гаргах	40
61 дүгээр зүйл. Шүүхэд гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх	41

62 дугаар зүйл. Хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх	41
63 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох.....	42

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ...-
ний өдөр

Улаанбаатар хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1.1. Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, холбогдох гомдлыг хянан шийдвэрлэх, хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбоотой асуудлаар Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуульд заасан журмыг мөн баримтална.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “ажил” гэж барилга байгууламжийн ажил, барилгын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил болон тухайн ажлыг дагалдан нийлүүлэх барааг.

3.1.2. “бараа” гэж эдийн засгийн ач холбогдол, үнэ бүхий худалдах, солилцох, түрээслэх боломжтой эд юмс болон тухайн барааг дагалдан үзүүлэх үйлчилгээг;

3.1.3. “барилга байгууламжийн ажил” гэж барилга байгууламжийг барих, өргөтгөх, шинэчлэх, их засвар болон өрөмдлөг, хайгуул хийх зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг;

3.1.4. “бичгээр” гэж захиалагч, сонирхогч этгээд, оролцогч, эсхүл холбогдох бусад этгээдээс цаасан хэлбэрээр үйлдэж эх хувиар хүргүүлснийг, эсхүл баримт бичгийг цахим системээр үйлдсэн баримт бичиг Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсгээр баталгаажуулсныг;

3.1.5. “гадаадын этгээд” гэж гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд, гадаадын иргэн, эсхүл харьяалалгүй хүнийг;

3.1.6. “дотоодын бараа” гэж Монгол Улсад олборлосон, ургуулсан, бойжуулсан, үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл хийж бүтээсэн барааг;

3.1.7. “ерөнхий гэрээ” гэж захиалагчаас байнгын давтамжтай эсхүл тодорхой цаг хугацаанд худалдан авдаг тоо хэмжээ, цаг хугацааны хувьд тодорхойгүй байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг нэг ба түүнээс дээш иргэн, аж ахуй эрхлэгчтэй үнэ болон бусад нөхцөлийг тохирч байгуулсан гэрээг;

3.1.8. “Захиалагч” гэж:

3.1.8.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

3.1.8.2. 50 ба түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;

3.1.8.3. Төсвийн тухай хуулийн 17.1-д заасан төслийн нэгж, Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасан төсөл хэрэгжүүлэгч;

3.1.8.4. Холбогдох хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, хуулиар эрх олгогдсоны үндсэн дээр олон нийтээс төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулдаг нийтийн эрх зүйн хуулийн этгээд.

3.1.9. “инновацийн бүтээгдэхүүн” гэж Инновацийн тухай хуулийн 3.1.4-т заасныг;

3.1.10. “нийгэм-эдийн засгийн бодлого” гэж хууль тогтоомжид зааснаар байгаль орчин, нийгэм, эдийн засгийн болон бусад бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах харгалзан үзэх шаардлагатай бодлогыг;

3.1.11. “оролцогч” гэж захиалагчаас хараат бус дараах иргэн, хуулийн этгээдийг ойлгоно:

3.1.11.1. дангаараа тендер ирүүлсэн этгээд;

3.1.11.2. гэрээний үндсэн дээр хамтран тендер ирүүлсэн хэд хэдэн этгээд.

3.1.12. “өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ” гэж зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээг.

3.1.13. “сонирхогч этгээд” гэж тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлсэн, эсхүл энэ хуулийн 17.4-т заасан үнэ төлсөн, эсхүл энэ хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтын урилга хүлээн авсан этгээдийг;

3.1.14. “тендер” гэж захиалагчийн тогтоосон нөхцөл, шаардлагын дагуу боловсруулж, түүнд ирүүлсэн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх тухай техникийн болон санхүүгийн саналыг;

3.1.15. “тендер шалгаруулалт” гэж энэ хуульд заасан журмын дагуу ирүүлсэн тендерийг холбогдох журмын дагуу урилга нийтлэх, тендер ирүүлэх, тендерийг хүлээн авах, тендерийг нээх, тендерийг үнэлэх, тендерийн үнэлгээний дүгнэлтийг захиалагчид хүргүүлэх, тендерээс татгалзах, гэрээ байгуулах эрх олгохыг;

3.1.16. “тендер шалгаруулалтын баримт бичиг” гэж захиалагчаас тендер шалгаруулалтын нөхцөл, аргачлалыг тодорхойлсон баримт бичгийг;

3.1.17. “техникийн тодорхойлолт” гэж худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавигдах технологийн шаардлагыг тодорхойлсон бүрдүүлбэрийг;

3.1.18. “үйлчилгээ” гэж энэ хуулийн **Error! Reference source not found.**-т заасан ажил гүйцэтгүүлэх, **Error! Reference source not found.**-т заасан бараа худалдан авах, түрээслэхээс бусад үйлчилгээг;

3.1.19. “тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил” гэж энэ хуулийн 3.1.3-т зааснаас бусад тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт, тохируулга хийх ажлыг;

3.1.20. “үнэлгээний хороо” гэж энэ хуульд заасан журмын дагуу тендер шалгаруулалт зохион байгуулах зорилгоор захиалагчийн байгуулсан бүрэлдэхүүнийг;

3.1.21. “худалдан авах ажиллагаа” гэж энэ хуульд заасан захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, зураг төсөл сонгон шалгаруулах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах, мэдээллийг олон нийтэд мэдээлэх ажиллагааг;

3.1.22. “цахим дэлгүүр” гэж ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан 3.1.24-т заасан цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг;

3.1.23. “цахим каталог” гэж бараа, ажил, үйлчилгээний мэдээллийг ангилсан 3.1.24-т заасан цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг;

3.1.24. “цахим систем” гэж цахим программ хангамжийг ашиглан худалдан авах ажиллагаа зохион байгуулах цогц үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоог;

4 дүгээр зүйл. Хууль үйлчлэх хүрээ

4.1. Улс, орон нутгийн төсөв болон энэ хуульд заасан захиалагчийн өөрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

4.2. Энэ хуулийн 4.1-д заасан төсөв, хөрөнгийн эх үүсвэрээр бараа, ажил, үйлчилгээний үнийн 50 ба түүнээс дээш хувийг төлөх нөхцөлтэй худалдан авах ажиллагаа зохион байгуулахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

4.3. Хуулиар төрийн нууцад хамааруулсан тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4.4. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд тусгайлан заасан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой үнэт цаас, валют худалдан авах, мөнгөн тэмдэгт хэвлүүлэх, хадгалуулах, тээвэрлэх, гадаад валютын улсын нөөцийг бүрдүүлэхтэй холбогдуулан гадаад валют, алт худалдан авах, цэвэршүүлэх, тээвэрлэх, банкны хяналт, шалгалтын хүрээнд зөвлөх үйлчилгээ авах, үндэсний төлбөрийн системийн программ хангамж, түүний тоног төхөөрөмж, эрдэнэсийн нөөц санг бүрдүүлэхэд хамаарах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4.5. Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны

нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

5 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны зарчим

5.1. Худалдан авах ажиллагаанд ил тод байдлыг хангах, өрсөлдөх тэгш боломжийг хангах, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

6 дугаар зүйл. Ерөнхий шаардлага

6.1. Дараах нөхцөл бүхий оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ:

6.1.1. төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах шийдвэр гарсан, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг зогсоосон, үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах аль нэг нөхцөл байдалд байгаа;

6.1.2. Монгол Улсын хуулийн дагуу татварын эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй, эсхүл өр төлбөр төлүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа;

6.1.3. гадаад улсын хуулийн этгээд бол үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагааг нь зогсоох боломжтой нөхцөл үүссэн;

6.1.4. захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг буюу хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын бүрэлдэхүүнийг зөвхөн захиалагчийн төлөөлөл томилох, чөлөөлөх эрхтэй, эсхүл үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлоход шийдвэрлэх нөлөө үзүүлэх боломжтой, эсхүл хуулийн этгээд нь захиалагчийн бодлого, байр суурийг илэрхийлдэг;

6.1.5. оролцогч, түншлэлийн гишүүнтэй Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай, эсхүл үгсэн хуйвалдсан гэж үзэх бодит үндэслэл байгаа;

6.1.6. оролцогч, эсхүл түүний төлөөлөх эрх бүхий этгээд, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан эцсийн өмчлөгч, эсхүл Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан авлигын гэмт хэрэг, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр сүүлийн 3 жилийн хугацаанд хуулийн хүчин төгөлдөр болсон;

6.1.7. тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахад зөвлөгөө өгсөн, эсхүл оролцсон, эсхүл тийм этгээдтэй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д заасан хамааралтай;

6.1.8. гэрээний хэрэгжилтийг хянахаар томилогдсон ажилтан, албан хаагч, эсхүл энэ зорилгоор сонгогдсон этгээдтэй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.6-д заасан хамааралтай;

6.1.9. энэ хуулийн 6.4-т заасан ерөнхий шаардлага хангахгүй этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй.

6.2. Оролцогч энэ хуулийн 6.1-д заасан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг бичгээр гаргана.

6.3. Энэ хуулийн 6.1-д заасан нөхцөлийг магадлахтай холбоотойгоор Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргуулан ирүүлэх баримт бичгийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

6.4. Энэ хуулийн 7.2-т заасан түншлэлийн гишүүн тус бүр энэ хуульд заасан ерөнхий шаардлага хангасан байх бөгөөд түншлэлийн гишүүн бүр холбогдох мэдэгдэл, баримт бичгийг энэ хуулийн 6.2, 6.3-т зааснаар ирүүлнэ.

7 дугаар зүйл. Түншлэл, туслан гүйцэтгэгч

7.1. Энэ хуулийн 3.1.11.2-т зааснаар хэд хэдэн этгээд хамтран тендер ирүүлсэн бол гишүүн тус бүрийн гүйцэтгэх үүргийн хэмжээ тендерийн үнийн 20 хувиас дээш байна.

7.2. Захиалагч дараах шаардлагыг хангасан гэрээний үндсэн дээр тендер ирүүлсэн түншлэлийг тендер шалгаруулалтын нэг оролцогч гэж үзнэ:

7.2.1. хамтарсан хуулийн этгээд байгуулахгүйгээр гэрээний үүргийг гүйцэтгэх бол Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан;

7.2.2. гэрээний үүрэг гүйцэтгэхэд бүх гишүүний хамтран болон тус бүр хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон;

7.2.3. худалдан авах ажиллагаанд түншлэлийг төлөөлөн оролцох, гэрээний хэрэгжилтийг захиалагч болон бусад этгээдийн өмнө хариуцах эрх бүхий нэг гишүүнийг томилсон.

7.2.4. түншлэлийн гишүүн тус бүр тендерт ирүүлэх өөрийн баримт бичгийн үнэн зөвийг хариуцах.

7.3. Оролцогч тендерийн үнийн 20 хүртэл хувийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх санал ирүүлж болно. Туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, уг гэрээг ирүүлнэ.

7.4. Захиалагч гадаадын этгээд, эсхүл тэдгээрийн түншлэл шалгарсан тохиолдолд Монгол Улсад хуулийн этгээд байгуулсны үндсэн дээр үүрэг гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно.

8 дугаар зүйл. Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, давуу эрх олгох

8.1. Энэ хуулийн 8.3-т заасан төсөвт өртгөөс хэтрэхгүй төсөвт өртөгтэй барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол зөвхөн дотоодын бараа авахаар тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

8.2. Энэ хуулийн 8.1-д заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

8.3. Захиалагч 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 300 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцож болно.

8.4. Энэ хуулийн 8.3-т зааснаас доош төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцох эрхгүй.

8.5. Оролцогч бараа нийлүүлэх, эсхүл ажил гүйцэтгэх тендерт дараах дотоодын барааг нийлүүлэх, эсхүл ашиглахаар тус тус санал болгосон бол давуу эрх олгоно:

- 8.5.1. Монгол Улсад хог хаягдлыг дахин боловсруулсан;
- 8.5.2. нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт үйлдвэрлэсэн түүхий эд, бараа, материалыг ашиглан үйлдвэрлэсэн;
- 8.5.3. Монгол Улсад үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн.
- 8.6. Энэ хуулийн 8.3-т зааснаас дээш төсөвт өртөгтэй ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтад дараах этгээдэд давуу эрх олгоно:
- 8.6.1. 50-аас доошгүй хувийг нь Монгол Улсын нэг эсхүл хэд хэдэн иргэд шууд, эсхүл шууд бусаар өмчилдөг Монгол Улсын хуулийн этгээд;
- 8.6.2. энэ хуулийн 8.6.1-д заасан этгээд түншлэлээр оролцох бол гэрээний үүргийн 50-аас доошгүй хувийг гүйцэтгэхээр санал ирүүлсэн.
- 8.7. Энэ хуулийн 8.5-д зааснаар давуу эрх олгоход дотоодын барааны хэсгийн үнийн 10 хувиар, 8.6-д зааснаар давуу эрх олгоход тендерийн үнийн 7.5 хувиар тус тус тендерийн үнийг хийсвэрээр бууруулж тооцон тендерийн харьцуулах үнийг тодорхойлно.
- 8.8. Энэ хуулийн 8.1-д зааснаар зөвхөн дотоодод үйлдвэрлэсэн бараа худалдан авахад давуу эрх олгохгүй.
- 8.9. Энэ хуулийн 8.7-д зааснаар давуу эрх эдлэхэд шаардлагатай мэдээлэл, нотлох баримтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тодорхой заана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ БЭЛТГЭХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ

9 дүгээр зүйл. Тендер шалгаруулалтын аргыг сонгох

- 9.1. Захиалагч тендер шалгаруулалтын аргыг сонгоход энэ хуулийн дөрөвдүгээр бүлэгт заасныг баримтална.
- 9.2. Захиалагч нийт төсөв нь 20 сая төгрөгөөс бага төсөвт өртөгтэй, цахим дэлгүүрт бүртгэгдээгүй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчимд нийцүүлэн шууд худалдан авч болно.
- 9.3. Батлагдсан нийт төсөвт өртгийг энэ хуулийн 9.2-т заасан босго үнэд багтаах зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт зохион байгуулахыг хориглоно.
- 9.4. Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор тендер шалгаруулалтыг бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хуваан зохион байгуулж болно.
- 9.5. Энэ хуулийн 9.4-т зааснаар тендер шалгаруулалтыг багцад хуваахад дараах шаардлагыг хангасан байна:
- 9.5.1. оролцогч тендер шалгаруулалтын хэдэн багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй байх;
- 9.5.2. багц тус бүрд үнэлгээ хийх ба нэг оролцогч хэд хэдэн багцад шалгарах бол гэрээ хэрэгжүүлэх чадавхыг дахин магадлах;
- 9.5.3. оролцогч хэд хэдэн багцад гэрээ байгуулах нөхцөлтэй үнийн хөнгөлөлт санал болгосон бол түүний шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн нэг, эсхүл хэд хэдэн багцад гэрээ байгуулахад бүх гэрээний үнийн дүн хамгийн бага байх хувилбарыг сонгох;
- 9.5.4. энэ хуулийн 8.1-д заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах багцыг тусад нь багцлах.

9.6. Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахим дэлгүүрт байршуулах бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуулийн 3.1.7-д заасан ерөнхий гэрээ байгуулж болно.

9.7. Энэ хуулийн 9.6-д заасан ерөнхий гэрээ байгуулах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар, ерөнхий гэрээний журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус батална.

9.8. Захиалагч гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг холбогдох олон улсын гэрээг соёрхон батлахаас өмнөх шатанд тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж болно.

9.9. Энэ хуулийн 9.8-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

10 дугаар зүйл. Тендер шалгаруулалтын баримт бичиг

10.1. Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, гэрээний маягт болон холбогдох бусад хууль, журам, аргачлалын дагуу боловсруулна.

10.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт оролцогч шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, оролцогчдод тавих шаардлага, заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, тендерийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтыг тусгана.

11 дүгээр зүйл. Техникийн тодорхойлолт

11.1. Захиалагч бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолтод шаардлагатай шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, холбогдох стандарт, техникийн норм, дүрэм, зааврыг тусгаж болно.

11.2. Энэ хуулийн 11.1-д зааснаар стандарт хэрэглэх тохиолдолд үндэсний стандарт байхгүй бол Монгол Улсын эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн олон улсын, гадаад улсын стандартыг заана.

11.3. Захиалагч оролцогчийн санал болгох барааг үйлдвэрлэх, нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгаж болно.

11.4. Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шинж чанар, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох ба үүний дотор байгаль орчин, уур амьсгалд нөлөөлөх нөлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх шалгуур үзүүлэлтийг тусгана.

11.5. Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй.

11.6. Бараа, ажил, үйлчилгээний үр дүнд бий болох аливаа оюуны өмчийн эрхийг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд эзэмших нөхцөлийг техникийн тодорхойлолтод зааж болно.

11.7. Захиалагч бараанд тавигдах шаардлагын техникийн үзүүлэлтийн хүлээн зөвшөөрч болох дээд, доод үзүүлэлтийг бараа худалдан авах хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн техникийн тодорхойлолтод тусгана.

11.8. Захиалагч зөвхөн энэ хуулийн 11.1-д зааснаар бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолтыг нарийвчлан хангалттай тодорхойлох боломжгүй үндэслэлээр энэ хуулийн 11.5-д заасан шаардлага, нөхцөлийг тавих бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэхүйц” гэсэн тодотгол хэрэглэнэ.

11.9. Энэ хуулийн 11.8-д заасныг баримтлан худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заасан нөхцөлтэй “дүйцэхүйц” бараа, ажил, үйлчилгээ болохыг оролцогч энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан баримт бичиг болон бусад зохих арга хэрэгслээр нотолсон бол захиалагч техникийн тодорхойлолт хангаагүй гэсэн үндэслэлээр татгалзахгүй.

11.10. Барилга байгууламж, дэд бүтэцтэй холбогдох аливаа худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтод Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.3-т заасан тохирох хэрэглэгдэхүүн, 4.1.4-т заасан түгээмэл загварыг зохих ёсоор тусгана.

12 дугаар зүйл. Техникийн тодорхойлолтод нийцэхийг нотлох баримт бичиг, дээж ирүүлэх

12.1. Захиалагч бараа, ажил, үйлчилгээ энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан техникийн тодорхойлолтыг хангах, эсхүл гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах тухай шалгалт, туршилтыг эрх бүхий бие даасан этгээдээр хийлгэсэн нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

12.2. Захиалагч шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 12.1-д заасан шалгалт, туршилтыг өөрөө зохион байгуулахаар техникийн тодорхойлолтод зааж болно.

12.3. Энэ хуулийн 12.2-т заасны дагуу шалгалт, туршилт зохион байгуулах тохиолдолд оролцогч өөрийн санал болгож буй бараа, ажил, үйлчилгээнд холбогдох загвар, дээжийг тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хүргүүлнэ.

12.4. Энэ хуулийн 12.2-т зааснаар шалгалт, туршилтыг хэрхэн зохион байгуулах тухай тендер шалгаруулалтын баримт бичигт тодорхой заах ба оролцогчдыг шалгалт, туршилтад оролцох боломжоор хангана.

12.5. Захиалагч хүлээн авсан дээж, загварыг шалгах, турших үйл явцыг зураг, дүрс бичлэгээр баримтжуулж хадгалах ба шалгараагүй оролцогчийн ирүүлсэн дээж, загварын ашиглаж болохуйц бараа бүтээгдэхүүнийг тендер шалгаруулалтын эцсийн шийдвэр гарч, гомдол гаргах хугацаа өнгөрснөөс хойш оролцогчдод буцаан олгоно.

13 дугаар зүйл. Тендерийн баталгаа

13.1. Захиалагч 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын оролцогчдыг тендерийн баталгаа ирүүлэхийг шаардана.

13.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт тендерийн баталгааны дагуу хүлээх үүргийн хэмжээг тухайн бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн 1 хувиар тогтооно.

13.3. Оролцогч тендерийн баталгааг дараах хэлбэрээр ирүүлж болно:

13.3.1. энэ хуулийн 13.2-т заасан дүнгээс багагүй мөнгөн төлбөрийн үүргийг захиалагчийн шаардлагаар гүйцэтгэх тухай банкны, эсхүл Төрийн сангийн баталгаа;

13.3.2. энэ хуулийн 13.2-т дүнгээс багагүй нэрлэсэн үнэтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг захиалагчийн шаардлагаар шилжүүлэх тухай эрх бүхий этгээдийн баталгаа.

13.4. Оролцогч тендерийн баталгааны үнийн дүнг гадаад валютаар илэрхийлж болох бөгөөд баталгааг хөрвүүлэх ханшийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Монголбанкны албан ханшаар тодорхойлно.

13.5. Гадаад улсын банк, эрх бүхий этгээдээр баталгаа гаргуулах тохиолдолд тендерийн баталгааны эх хувийг албан ёсны орчуулгын хамт ирүүлнэ.

13.6. Гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах эрхийг зөвхөн гадаадын этгээд эдлэх бөгөөд энэ тохиолдолд баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдээр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагыг тодорхой заасан байна.

13.7. Тендерийн баталгаа шаардсан нөхцөлд түүнийг ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн баталгаа нь энэ хууль болон тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй бол захиалагч тухайн тендерээс татгалзана.

13.8. Дараах тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгоно:

13.8.1. оролцогч тендерийг нээсний дараа, тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсан;

13.8.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу гэрээ байгуулах, гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх үүргээ биелүүлээгүй, тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариу ирүүлээгүй;

13.8.3. энэ хуулийн 60 дугаар зүйлд заасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

13.9. Гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер хүчинтэй байх хугацаанд энэ хуулийн 31.2-т зааснаар гэрээг баталгаажуулсан бол захиалагч гэрээ баталгаажуулах хүртэл түүний тендерийн баталгаа хүчинтэй байна.

13.10. Энэ хуулийн 13.9-д зааснаас бусад тохиолдолд оролцогчийн ирүүлсэн тендерийн баталгааны хүчинтэй хугацаа дуусах хүртэл, эсхүл захиалагч шалгарсан оролцогчтой гэрээ байгуулсан үндэслэлээр цуцлахыг захиалагч зөвшөөрөх хүртэл хугацаанд хүчинтэй байна.

13.11. Оролцогч тендер шалгаруулалтын хэд хэдэн багцад оролцохтой холбоотой баталгааг нэг тендерийн баталгаагаар ирүүлсэн бол аль нэг багцад ирүүлсэн тендерийн баталгааг улсын орлого болгох, эсхүл хугацаанаас өмнө цуцлах хэмжээ нь тухайн багцад гаргах тендерийн баталгааны үнийн дүнгээр хязгаарлагдана.

13.12. Энэ хуульд зааснаар тендерийн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргах, улсын орлого болгох журам, Монгол Улсын Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны жагсаалтыг тус тус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

13.13. Ерөнхий гэрээ байгуулах тендер шалгаруулалтад 13.3-т заасан хэлбэрээр тендерийн баталгаа ирүүлэхийг шаардахгүй.

14 дүгээр зүйл. Оролцогчийн чадавхын шаардлага

14.1. Захиалагч энэ хуулийн 15-16 дугаар зүйлд заасан гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээдийн болон оролцогчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно.

14.2. Худалдан авах ажиллагаанд цахим системээр дамжуулан лавлах, тодруулах боломжтой болон хууль тогтоомжийн дагуу төрийн эрх бүхий байгууллагаас нийтэд ил тод хөтөлдөг мэдээллийг нотлох баримт бичиг ирүүлэхийг захиалагч оролцогчоос шаардахгүй.

14.3. Гэрээг тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэх шаардлагатай бол захиалагч энэ тухай тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

14.4. Захиалагч шаардсан тохиолдолд оролцогч хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг ирүүлнэ.

14.5. Энэ хуулийн 14.4-т заасан мэдээлэл оролцогчийн санхүүгийн болон техникийн доод чадавх, туршлагыг нотлох баримтад хамаарна.

14.6. Оролцогч энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан туршлагын мэдээллийг санхүүгийн болон татварын тайланд зохих ёсоор тусгасан байна.

15 дугаар зүйл. Санхүүгийн чадавхын шаардлага

15.1. Захиалагч санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно.

15.2. Санхүүгийн чадавхын талаарх дараах мэдээллийг холбогдох баримт бичгээр нотолж болно:

15.2.1. харилцагч банкны мэдэгдэл;

15.2.2. үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан;

15.2.3. хуулийн дагуу санхүүгийн тайлангийн аудит хийлгэх үүрэг бүхий оролцогчийн хувьд энэ хуулийн 15.2.2-т заасан санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт;

15.2.4. сүүлийн 5 хүртэл жилийн хугацаанд оролцогч тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт хэрэгжүүлсэн борлуулалтын орлогын мэдээлэл.

15.3. Захиалагч энэ хуулийн 15.2-т заасан баримт бичгээс аль шаардлагатайг ирүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно. Баримт бичигт тавигдах шаардлагыг тодорхой заана.

15.4. Захиалагч санхүүгийн тайлан ирүүлэх хугацааг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

15.5. Оролцогч захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг бүрэн хангасан байна.

15.6. Түншлэл гишүүдийн тооноос үл хамааран захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын доод шаардлагыг хамтдаа бүрэн хангасан байх бөгөөд гишүүн тус бүрийн хангасан байвал зохих санхүүгийн чадавхыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

16 дугаар зүйл. Техникийн чадавх болон туршлагын шаардлага

16.1. Захиалагч техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно.

16.2. Техникийн чадавх, туршлагын талаарх дараах мэдээллийг холбогдох баримт бичгээр нотолж болно:

16.2.1. ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн 5 хүртэл жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг нотлох баримт, шаардлагатай бол ажил гүйцэтгэлийн талаарх өмнөх захиалагчийн тодорхойлолт;

16.2.2. бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн 5 хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, бүрэн нийлүүлсэн, гүйцэтгэсэн болохыг нотлох баримт, шаардлагатай бол бараа, үйлчилгээний гүйцэтгэлийн талаарх өмнөх худалдан авагчдын тодорхойлолт;

16.2.3. ажил гүйцэтгэх тендер болон угсралт, суурилуулалтын ажил оролцуулсан бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер ирүүлэх тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, түүний боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл;

16.2.4. гэрээний үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний мэдээлэл;

16.2.5. гэрээний үүргийг гүйцэтгэхтэй холбоотой багаж, техник хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн байрны мэдээлэл;

16.2.6. бараа нийлүүлэх тендерийн хувьд нийлүүлэх барааны загвар, тодорхойлолт, гэрэл зураг, шаардлагатай бол тэдгээрийн үнэн зөвийг гэрчилсэн баримт;

16.2.7. нийлүүлэхээр санал болгосон барааг чанар, стандартын шаардлага хангасан талаарх мэдээлэл.

16.3. Захиалагч энэ хуулийн 16.2-т заасан баримт бичгээс аль шаардлагатайг ирүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно. Баримт бичигт тавигдах шаардлагыг тодорхой заана.

16.4. Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

16.5. Түншлэл гишүүдийн тооноос үл хамааран захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын доод шаардлагыг хамтдаа бүрэн хангасан байх бөгөөд гишүүн тус бүрийн хангасан байвал зохих техникийн чадавх болон туршлагын шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

16.6. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн үүрэг энэ хуулийн 14.3-т заасан тусгай зөвшөөрөл, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардах бол туслан гүйцэтгэгч энэ шаардлагыг хангасан байна.

16.7. Захиалагч оролцогчид тавигдах техникийн чадавх болон туршлагын шаардлагыг тодорхойлоход бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагад үндэслэх ба үндэслэлгүйгээр оролцогчийн үүсгэн байгуулагдсан хугацааны болон санхүү, техникийн чадавхийн шаардлага тавихгүй.

17 дугаар зүйл. Тендер шалгаруулалтын зарлал

17.1. Захиалагч энэ хуулийн 9.2-т заасан босго үнээс давсан төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, сонирхогч этгээд танилцах боломжоор хангана.

17.2. Энэ хуулийн 8.3-т заасан босго үнээс давсан тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг монгол хэлээс гадна олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэлээр бэлтгэж, гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудааст нийтэлж болно.

17.3. Тендер шалгаруулалтын зарлалд дараах мэдээллийг тусгана:

17.3.1. захиалагчийн нэр, хаяг;

17.3.2. бараа, ажил, үйлчилгээний товч агуулга, төсөвт өртөг;

17.3.3. тендер шалгаруулалтын арга;

17.3.4. энэ хуулийн 22.4-т заасан тохиолдолд тендер хүргүүлэх хаяг;

17.3.5. тендер хүлээн авах эцсийн хугацаа;

17.3.6. тендер нээх хугацаа;

17.3.7. тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх;

17.3.8. тендер үнэлэх шалгуур үзүүлэлтийн мэдээлэл;

17.3.9. гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх.

17.4. Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийг оролцогчдод олгохтой холбоотой үйл ажиллагааны бодит зардлыг үндэслэн тендер шалгаруулалтын баримт бичгийг худалдаж болно.

18 дугаар зүйл. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах

18.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө захиалагчид гаргаж болно.

18.2. Захиалагч тодруулгын хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор цахим системд нээлттэй байршуулна.

18.3. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

19 дүгээр зүйл. Тендер ирүүлэх болон хүчинтэй байх хугацаа

19.1. Захиалагч сонирхогч этгээдэд тендер бэлтгэж ирүүлэх хангалттай, ижил хугацаа олгоно.

19.2. Тендер бэлтгэх зорилгоор ажлын талбайтай танилцах шаардлагатай бол түүнд шаардагдах хугацааг энэ хуулийн 19.1-д заасан хугацаанд оруулан тооцно.

19.3. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацааг тендер шалгаруулалтыг цахим системд зарлан мэдээлсэн өдрөөс эхлэн тооцно.

19.4. Тендер хүлээн авах хугацааг энэ хуулийн дөрөвдүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын арга тус бүрд заасан журмаар зохицуулна.

19.5. Захиалагч гадаадын этгээд оролцох эрхтэй тендер шалгаруулалтын тендер хүлээн авах эцсийн хугацааг тогтооход энэ хуулийн дөрөвдүгээр бүлэгт

заасан тендер шалгаруулалтын арга тус бүрд зааснаас доод хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийг нэмж тооцно.

19.6. Оролцогчийн ирүүлсэн тендерийн хүчинтэй байх хугацаа тендер нээсэн өдрөөс хойш 30-аас доошгүй хоног байна.

19.7. Захиалагч тендер ирүүлэхийн өмнө сонирхогч этгээд, түүний төлөөлөлтэй уулзалт зохион байгуулах, ажлын талбайтай танилцуулах бол энэ тухай тендер шалгаруулалтын баримт бичигт заана. Уулзалтаар тендер бэлтгэх явцад үүсэж болох аливаа асуудлыг тодруулах, энэ талаар сонирхогч этгээдийн тавьсан асуултад хариулт өгнө.

19.8. Сонирхогч этгээд тендер ирүүлэхийн өмнөх уулзалтад оролцоогүй, ажлын талбайтай танилцаагүй нь тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлахгүй.

20 дугаар зүйл. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

20.1. Тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт товлосон хугацаанд, дурдсан хаягаар, заасан хэлбэрээр ирүүлэх ба тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө өөрийн тендерт нэмэлт, өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцаан авч болно.

20.2. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш тендерт нэмэлт, өөрчлөлт оруулах, солих эрхгүй ба тендерийг буцаан олгохгүй.

20.3. Захиалагч энэ хуулийн 18.3-т зааснаар тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол тендер хүлээн авах хугацааг уг нэмэлт, өөрчлөлт орсноос хойш ажлын 5-аас доошгүй хоног байхаар сунгана.

21 дүгээр зүйл. Тендер бэлтгэх

21.1. Сонирхогч этгээд тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт нийцүүлэн бэлтгэнэ.

21.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээллийг төрийн эрх бүхий байгууллагаас гаргуулах, холбогдох этгээдээс лавлагаа, тодорхойлолт авах, гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд өөрийн тендерийн холбогдох хэсгийг бусад оролцогчдод ил болгох зөвшөөрлийг олгосон байна.

21.3. Тендер бэлтгэх, илгээх, тендер шалгаруулалтад оролцохтой холбогдох бүх зардлыг сонирхогч этгээд, оролцогч бүрэн хариуцна.

21.4. Оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасан маягтад үндэслэн тендерийг бэлтгэх ба маягтын дагуу оролцогчийн хүлээх үүрэг хариуцлага, мэдэгдэл, баталгаанд өөрчлөлт оруулахгүйгээр боловсруулан ирүүлнэ.

21.5. Оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасан маягтыг бөглөхдөө цахим системийн холбогдох талбарын мэдээллийг бөглөж ирүүлнэ.

21.6. Энэ хуулийн 21.5-д заасан цахим системийн талбарын мэдээлэл нь тендерт ирсэн баримт бичигтэй зөрсөн бол цахим системийн мэдээллийг баримтална.

21.7. Захиалагч өөрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хэрэгцээ шаардлагыг хангах хувилбарт саналыг тендерт ирүүлэхийг зөвшөөрсөн бол оролцогч хувилбарт саналыг үнийн хамт үндсэн тендерт хамт илгээж болно.

22 дугаар зүйл. Тендер баталгаажуулж ирүүлэх, тендерийг хүлээн авах

22.1. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт заасан арга, хэлбэрээр цахим системээр илгээнэ.

22.2. Оролцогч тухайн тендер шалгаруулалтад зөвхөн нэг тендер ирүүлнэ.

22.3. Энэ хуулийн 21.7-д зөвшөөрсний дагуу тендерийг хувилбарт саналтайгаар ирүүлэх нь энэ хуулийн 22.2-т заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

22.4. Энэ хуулийн 8.3-т заасан тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд цахим системээр тендер илгээх боломжгүй бол тендерийг цахим бус хэлбэрээр энэ хуулийн 17.3.4-т заасан хаягаар захиалагчид хүргүүлж болно.

22.5. Оролцогч дор дурдсанаас бусад баримт бичиг, мэдээллийг хуульд зааснаар байгууллагын болон хувь хүний нууцыг хамгаалах үндэслэлээр бусад оролцогчдод танилцуулахаас татгалзаж болох бөгөөд тухайн баримт бичиг, мэдээллийг нууцад хамаарахыг тайлбарласан мэдэгдлийг гаргана.

22.5.1. энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан ерөнхий нөхцөлийг хангахыг нотлох баримт бичиг;

22.5.2. тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу боловсруулсан баримт бичиг;

22.5.3. захиалагчаас ил байхаар тусгайлан заасан баримт бичиг.

22.6. Энэ хуулийн 22.5-д зааснаар нууцлах баримт бичиг, мэдээллийг тендерт тусад нь хавтаслаж, эсхүл цахим системийн холбогдох талбарт оруулан тусад нь илгээнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТЕНДЕР ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ

23 дугаар зүйл. Тендер нээх

23.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацааны дотор хүлээн авсан бүх тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан газар, товлосон хугацаанд цахим системээр нээнэ.

23.2. Тендер нээх хугацааг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор байхаар товлоно.

23.3. Энэ хуулийн 22.4-т зааснаар цахим бус хэлбэрээр хүлээн авсан тендерийг захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт заасан газарт нээх ба оролцогч, түүний төлөөлөгчийг болон сонирхсон бусад этгээд уг нээлтэд оролцож болно.

23.4. Тендер нээх үед дараах мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ:

23.4.1. оролцогчийн нэр;

23.4.2. тендерийн үнэ;

23.4.3. санал болгосон үнийн хөнгөлөлт, түүнийг хэрэглэх аргачлал заасан бол аргачлалын мэдээлэл;

23.4.4. хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ;

23.4.5. тендерийн баталгаа ирүүлсэн эсэх;

23.4.6. цаасаар хүлээн авсан тендерийг оролцогч өөрчилсөн, эсхүл буцаан авсан тухай мэдээлэл.

23.5. Энэ хуулийн 23.3-т заасан тендерийн нээлтэд байлцсан этгээдээр нээлтийн тэмдэглэлд гарын үсэг зуруулж, тус тэмдэглэлийг цахим системд нийтэлнэ.

23.6. Энэ хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар тендерийн үнийг нэг валютад хөрвүүлэх болон тендерийн үнийн арифметик алдааг залруулснаас бусад тохиолдолд тендер шалгаруулалтын нээлтэд зарлагдаагүй, тэмдэглэлд заагаагүй тендерийн болон хувилбарт саналын үнэ, үнийн хөнгөлөлтийг үнэлгээнд харгалзахгүй.

24 дүгээр зүйл. Тендер хянан үзэх, үнэлэх хугацаа

24.1. Захиалагч аль болох богино хугацаанд тендерийг хянан үзэх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох ажиллагааг хийх ба тендер нээснээс хойш ажлын 15 хоногоос хэтрэхгүй байна.

24.2. Тендер шалгаруулалтын гомдол шийдвэрлэх зөвлөлөөс энэ хуулийн 60.12-д заасан шийдвэрийг гаргасантай холбоотойгоор захиалагч энэ хуулийн 24.10-д заасан хугацааг ажлын 10 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

24.3. Энэ хуулийн 24.2-т зааснаар сунгасан бол захиалагч бүх оролцогчдод мэдэгдэж, энэ хугацаанаас өмнө тендерийн хүчинтэй хугацаа дуусгавар болох оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг хүргүүлнэ.

24.4. Оролцогч өөрийн тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах бол бичгээр мэдэгдэх ба ийнхүү сунгаагүй нь түүний тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болохгүй.

25 дугаар зүйл. Тендерийн талаар тайлбар, тодруулга авах

25.1. Захиалагч тендер, эсхүл холбогдох мэдээллийн сангаас авсан оролцогчийн мэдээлэл ойлгомжгүй, тодорхойгүй, эсхүл зөрчилдөөнтэй гэж үзвэл уг асуудлыг тодруулах, тайлбар авах зорилгоор энэ зүйлд заасны дагуу тайлбар, тодруулгыг бичгээр ирүүлэхийг оролцогчоос шаардана.

25.2. Захиалагч энэ хуулийн 25.1-д заасан мэдээллийг холбогдох бусад этгээдээс цахим шуудангаар эсхүл бичгээр тодруулж болно.

25.3. Захиалагч энэ хуулийн 28.1-д зааснаар хэт бага үнийн саналыг тодруулах, эсхүл энэ хуулийн 29.5.1-т зааснаар тендерийн үнэд хийсэн арифметик алдааг хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд оролцогчийн тендерийн үнэ, үнийн хөнгөлөлтийн талаар тодруулга авахгүй.

25.4. Энэ хуулийн 25.1, 25.2-т зааснаар гаргасан захиалагчийн хүсэлт, түүний хариуг тендер шалгаруулалтын хавтаст хадгална.

25.5. Энэ хуулийн 25.1-25.3-т зааснаар тодруулга авах, эсхүл хуульд заасан үндэслэлээр оролцогчтой хэлэлцээ хийхээс бусад тохиолдолд захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хорооны гишүүн тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд оролцогч, түүний төлөөлөгчтэй аливаа хэлбэрийн уулзалт зохион байгуулахгүй, шууд болон шууд бусаар холбоо тогтоохгүй.

26 дугаар зүйл. Тендерийн нууцлал

26.1. Захиалагч тендер шалгаруулалтын явцад олж мэдсэн оролцогчийн техникийн болон бизнесийн нууцыг хуульд зааснаас бусад тохиолдолд хадгална.

26.2. Захиалагч тендерийн үнэлгээний явц болон оролцогчийн чадавхыг хянан үзэхтэй холбоотой мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд задруулахгүй.

26.3. Захиалагч гэрээ байгуулах эрх олгосон бол шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендерээс энэ хуулийн 22.5-д зааснаар нууцалснаас бусад хэсэг, холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас авсан мэдээллээс хувь хүний нууцад хамаарахгүй хэсгийг бусад оролцогчдод цахим системээр танилцах боломж олгоно.

26.4. Энэ хуулийн 26.3-т зааснаар шалгарсан оролцогчид холбогдох баримт, мэдээллийг танилцуулах хугацаа нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш энэ хуулийн 60.1-д зааснаар гомдол гаргах боломжтой хугацаа дуусах хүртэл байна.

26.5. Энэ хуулийн 22.4-т заасны дагуу хүлээн авсан тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан газарт, ажлын цагаар бусад оролцогчдод танилцуулж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

26.6. Гэрээ байгуулах эрх авсан оролцогчийн тендертэй танилцсан оролцогч, түүний төлөөлөгч тендер, түүнд агуулсан баримт бичгийг хуулбарлах эрхгүй.

27 дугаар зүйл. Тендер хянан үзэх

27.1. Тендер хянан үзэхэд захиалагч оролцогчийн ирүүлсэн тендер, энэ хуулийн 14.2-т заасан мэдээллийн сан, энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан тайлбар, тодруулгын хүрээнд хянан үзнэ.

27.2. Тендер нээсний дараа захиалагч тендер дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ:

27.2.1. оролцогч энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага хангахгүй гэж үзэх үндэслэл байгаа эсэх;

27.2.2. энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлага хангасан байх;

27.2.3. санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх;

27.2.4. захиалагчаас тогтоосон эсхүл холбогдох гэрээний нөхцөлөөр тодорхойлсон талуудын эрх, үүргийг хүлээн зөвшөөрсөн байх;

27.2.5. тендер шалгаруулалтын баримт бичигт заасан нөхцөл, шаардлага.

27.3. Захиалагч энэ хуулийн 27.2.1-д заасан ерөнхий шаардлага хангах эсэхийг хянан үзэхэд оролцогчийн энэ хуулийн 6.2-т заасан мэдэгдлийг үнэн зөв гэж үзэх ба энэ хуулийн 6.3-т заасан баримт бичиг болон холбогдох мэдээллийн сангийн хүрээнд магадлахад шаардлага хангахгүй гэж үзэх нөхцөл тогтоогдохгүй бол ерөнхий шаардлага хангасан гэж үзнэ.

27.4. Оролцогч энэ хуулийн 6.2-т заасан мэдэгдлийн үнэн зөвийг хариуцах бөгөөд худал мэдүүлсэн нь тогтоогдвол захиалагч түүний тендерээс татгалзаж, хуульд заасан бол оролцогчтой холбоотой дүгнэлт гаргуулахаар худалдан авах ажиллагааны улсын байцаагчид санал хүргүүлнэ.

27.5. Тендерт дараах зөрүү байгаа нь жижиг хэмжээний бөгөөд хүлээн зөвшөөрөх нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зорилгод нийцсэн, бусад оролцогчдод зүй бус сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзвэл шаардлага хангасан гэж үзнэ:

27.5.1. энэ хуулийн 27.2.3-т зааснаар хянан үзэхэд бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй;

27.5.2. энэ хуулийн 27.2.4-т зааснаар хянан үзэхэд захиалагчийн тодорхойлсон гэрээний нөхцлөөс зөрүүтэй санал болгосон ч тухайн нөхцөл нь хууль тогтоомжоор хориглосон эрх, үүргийг шаардаагүй.

27.6. Энэ хуулийн 27.1-д зааснаар хянан үзэхэд бүх шаардлагыг нэгэн зэрэг хангаж байгаа, баталсан төсөвт өртгөөс хэтрээгүй тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

27.7. Энэ хуулийн 27.6-д зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж татгалзана.

27.8. Оролцогч тендер шалгаруулалтын баримт бичгээр шаардаагүй баримт бичгийг ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

27.9. Ерөнхий гэрээний нэгдүгээр шатны тендер шалгаруулалтад худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага оролцогчоос ерөнхий гэрээний тендерийн баримт бичгийн дагуу ирүүлсэн тендерийг энэ хуулийн 27.1-д зааснаар хянан үзнэ.

28 дугаар зүйл. Хэт бага үнэтэй тендер

28.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтад 3 ба түүнээс дээш тооны оролцогч тендер ирүүлсэн бол нийт шаардлагад нийцсэн тендерийн дундаж үнээс 20 хувиар бага үнэ бүхий тендерийн бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой эсэхийг магадлах зорилгоор захиалагч тухайн тендерийн үнэ бага байгаа үндэслэлийн талаар тайлбарыг оролцогчоос гаргуулж болно.

28.2. Оролцогч энэ хуулийн 28.1-д заасан тайлбарыг захиалагч мэдэгдсэнээс хойш ажлын 2 хоногийн дотор захиалагчид хүргүүлнэ.

28.3. Оролцогч тендерийг үнэ, түүнийг бүрдүүлсэн зардал бага байлгах бодит нөхцөл боломж байгаа бөгөөд энэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй болохыг нотолсон бол түүний тендерээс татгалзахгүй.

29 дүгээр зүйл. Тендер үнэлэх

29.1. Нэг үе шаттай нээлттэй тендер шалгаруулалтын үед энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу шаардлагад нийцсэн гэж үзсэн, 28 дугаар зүйлд зааснаар хэт бага үнэтэй гэж тооцогдоогүй бүх тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан үнэлгээний үндсэн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

29.2. Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь дараах байна:

29.2.1. тендерийн үнэ;

29.2.2. ашиглалтын хугацааны зардал; эсхүл

29.2.3. чанар-үнийн хосолмол;

Тайлбар: Захиалагч тендерт оролцогчийн санал болгож буй бараа, ажил, үйлчилгээ болон санал болгож буй үнэд оноо өгч, хамгийн өндөр оноо авсан этгээдэд гэрээ байгуулах эрх олгох.

29.3. Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний онцлогийг харгалзан байгууллагын эдийн засгийн үр ашигт нөлөөлөх дараах шалгуур

үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн тендерийн үнэ дээр нэмж тооцохоор тусгаж болно:

29.3.1. бараа хүргэх, ажил, үйлчилгээ дуусгах хугацаа;

29.3.2. борлуулалтын дараах үйлчилгээ; эсхүл

29.3.3. энэ хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт.

29.4. Энэ хуулийн 29.3-т заасан нэмж тооцох үнэлгээ нь зөвхөн тендерийг харьцуулах үнийг тооцох зорилготой бөгөөд тендерийн үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

29.5. Захиалагч энэ хуулийн 29.2.1-д заасан үндсэн шалгуурыг хэрэглэх тохиолдолд шаардлагад нийцсэн тендерүүдийг дараах байдлаар үнэлнэ:

29.5.1. тендерийн үнэд арифметик алдаа гаргасан эсэхийг шалгаж, алдаа гаргасан бол түүнийг залруулах;

29.5.2. үнийн хөнгөлөлтийг аргачлалын тооцох, аргачлал заагаагүй бол тендерийн үнээс тооцох;

29.5.3. тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас өөр валютаар тендерийн үнийг тооцож ирүүлсэн тохиолдолд түүнийг хөрвүүлэх ханшийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Монголбанкны албан ханшаар тооцож хөрвүүлэх;

29.5.4. энэ хуулийн 8.7-д зааснаар давуу эрх тооцох;

29.5.5. энэ хуулийн 29.3-т заасан шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт хэрэглэхээр тусгасан бол үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх.

29.6. Захиалагч энэ хуулийн 29.5-д заасны дагуу үнэлэгдсэн тендерүүдийн өсөх дарааллаар эрэмбэлж, хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

29.7. Захиалагч хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг энэ хуулийн 29.5.1-29.5.3-т зааснаар үнэлсний дараах үнийг гэрээний үнээр тогтоож, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заана.

29.8. Энэ хуулийн 29.5.4, 29.5.5-д зааснаар тендерийн харьцуулах үнийг хийсвэрээр тооцсон нь гэрээний үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

29.9. Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгайлан заагаагүй гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой татвар, даатгал, тээвэрлэлтийн болон бусад бүх зардлыг тендерийн үнэд багтааж тооцох бөгөөд эдгээр зардлыг тусгайлан тооцоогүй бол захиалагч тухайн зардлыг тендерийн үнэд багтсан гэж үзнэ.

29.10. Захиалагч энэ хуулийн 29.3-т дурдсан шалгуур үзүүлэлт нь зөвхөн санал болгох бараа, ажил, үйлчилгээнд хамаарах ба оролцогч чадавх, туршлагын шаардлагыг давуулан хангах нь түүний харьцуулах үнэд өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй.

29.11. Ерөнхий гэрээний нэгдүгээр шатны тендер шалгаруулалтад энэ хуулийн 27.9-д зааснаар хянан үзэхэд шаардлагад нийцсэн бүх тендерийг дараах байдлаар үнэлнэ:

29.11.1. Оролцогчийн ирүүлсэн тендерийн нэгж үнийг зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон босго нэгж үнийн дээд хязгаартай харьцуулах;

29.11.2. Оролцогчийн ирүүлсэн тендер 29.11.1-д заасан үнэтэй тэнцүү буюу түүнээс бага үнийн санал ирүүлсэн бол шаардлагад нийцсэн гэж үзэж, гэрээ байгуулах эрх олгох;

29.11.3. Оролцогчийн ирүүлсэн тендер 29.11.1-д заасан үнээс өндөр үнийн санал ирүүлсэн бол тендерт шалгараагүй гэж үзэх.

29.12. Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

29.13. Энэ хуулийн 29.2.2, 29.2.3-т заасан шалгуур үзүүлэлтийг хэрэглэх аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30 дугаар зүйл. Захиалагч шийдвэр гаргах, түүнийг танилцуулах

30.1. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох, эсхүл бүх тендерээс татгалзах шийдвэрийг бүх оролцогчид нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

30.2. Энэ хуулийн 30.1-д заасан мэдэгдлийг тухайн өдөрт багтаан цахим системд нийтэлснээр оролцогчид хүргүүлсэнд тооцно.

30.3. Гэрээ байгуулах эрх олгосон бол бусад оролцогчдод тендерээс татгалзсан болон шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг хүргүүлнэ.

30.4. Бүх тендерээс татгалзсан бол татгалзсан үндэслэлийг оролцогч тус бүрд мэдэгдэж, тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулах эсэх талаар оролцогчдод мэдэгдэнэ.

30.5. Захиалагч шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй бол бүх тендерээс татгалзаж, шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтын баримт бичигт шаардлагатай өөрчлөлт оруулж, дахин ижил журмаар, эсхүл илүү өрсөлдөөнт журмаар шалгаруулна.

30.6. Энэ хуулийн 31.3-т заасан үндэслэлээр захиалагч гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосон бол шаардлага хангасан тендерээс энэ хуулийн 29.6-д заасан эрэмбийн дараагийн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

31 дүгээр зүйл. Гэрээнд гарын үсэг зурах

31.1. Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт заасан гэрээний нөхцөлд үндэслэн шалгарсан оролцогчтой байгуулах гэрээ баталгаажуулах маягыг энэ хуулийн 39 дүгээр зүйлд нийцүүлэн боловсруулж, шалгарсан оролцогчид хүргүүлнэ.

31.2. Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд энэ хуулийн 31.1-д заасан гэрээ баталгаажуулах маягтад гарын үсэг зурж, эсхүл цахим системээр баталгаажуулан захиалагчид хүргүүлнэ.

31.3. Тендер шалгаруулалтад зөвхөн нэг оролцогч тендер ирүүлж шалгарсан, эсхүл ерөнхий гэрээний тендер шалгаруулалтын нэгдүгээр шатанд гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд захиалагч энэ хуулийн 31.1-д заасан гэрээ байгуулах хугацаа болон энэ хуулийн 26.3-т зааснаар шалгарсан оролцогчийн тендерийг бусад оролцогчдод танилцуулах журам хамаарахгүй.

31.4. Энэ хуулийн 13.8.2-т заасан нөхцөл үүссэн, эсхүл тендер шалгаруулалтын гомдол шийдвэрлэх зөвлөлийн болон шүүхийн шийдвэрээр гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосноос бусад тохиолдолд захиалагч гэрээг баталгаажуулан архивын нэгж болгон хадгална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГА

32 дугаар зүйл. Тендер шалгаруулалтын арга

32.1. Захиалагч худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийг баримтлан зохион байгуулна:

32.1.1. Нээлттэй тендер шалгаруулалт;

32.1.2. Өрсөлдөөнт хэлэлцээ;

32.1.3. Үнийн санал цахимаар дуудах;

32.1.4. Нэг эх үүсвэрээс худалдан авах;

32.1.5. Ерөнхий гэрээ байгуулах.

32.2. Энэ хуульд өөр арга хэрэглэхээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд захиалагч нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

33 дугаар зүйл. Нээлттэй тендер шалгаруулалтын арга

33.1. Нээлттэй тендер шалгаруулалтын зарлалыг энэ хуулийн 17.1-д заасны дагуу нийтэлж, сонирхогч этгээдийг оролцох тэгш боломжоор хангана.

33.2. Нээлттэй тендер шалгаруулалтад тендер хүлээн авах эцсийн хугацааг энэ хуулийн 17.3-т заасан зарлал нийтэлснээс хойш дараах хугацаагаар заана:

33.2.1. ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх тендер хүлээн авахад ажлын 15 ба түүнээс дээш хоног;

33.2.2. бараа нийлүүлэх тендер хүлээн авахад ажлын 7 ба түүнээс дээш хоног.

33.3. Энэ хуулийн 34 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын аргыг нэг үе шаттай зохион байгуулна.

33.4. Энэ хуулийн 54 дүгээр зүйлд зааснаар цахим системд бүртгэлтэй иргэн, аж ахуй эрхлэгчид тендер шалгаруулалтын урилгыг цахим системээр хүргүүлж болно.

33.5. Энэ хуулийн 33.4-т зааснаар урилга хүргүүлсэн нь тухайн иргэн, аж ахуй эрхлэгчид бусад оролцогчоос давуу байдал олгох, эсхүл бусад оролцогчийг тендер ирүүлэхийг хориглох үндэслэл болохгүй.

34 дүгээр зүйл. Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулах

34.1. Захиалагч бараа, ажил, үйлчилгээний цар хүрээ их, төсөвт өртөг өндөр, хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн бараа, ажил, үйлчилгээг цогцоор нь гүйцэтгэх шаардлагатай бөгөөд техникийн тэгш бус санал ирэх магадлалтай, эсхүл өгөгдсөн шаардлагыг хангах, ижил хэмжээнд хүлээн зөвшөөрөхүйц хоёр, түүнээс дээш техникийн шийдэл байх боломжтой гэж захиалагч үзсэн бол нээлттэй тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж болно.

34.2. Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд бараа, ажил, үйлчилгээний хүрээнд хангахыг зорьж буй захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг ерөнхийд нь тодорхойлсон техникийн тодорхойлолт бүхий тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, энэ хуулийн 17.1-д зааснаар зарлана.

34.3. Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичиг болон зарлалд энэ хуулийн 17.3-т зааснаас гадна хоёр үе шаттай зохион байгуулах баримтлах журмыг заана.

34.4. Нэгдүгээр шатанд техникийн санал ирүүлэх сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангахуйц бараа, ажил, үйлчилгээний шийдлийг санал болгосон байна.

34.5. Захиалагч нэгдүгээр үе шатанд ирүүлсэн техникийн шийдлийг судалж, шаардлагатай бол сонирхогч этгээдээс тодруулга, нэмэлт мэдээллийг авсны үндсэн дээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг эцэслэн боловсруулсан тендер шалгаруулалтын баримт бичгийг нийтэлж, ажлын 15-аас доошгүй хугацааны дотор тендер шалгаруулалтын хоёрдугаар шатанд тендер хүлээн авахаар зарлана.

34.6. Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд эхний шатанд оролцоогүй этгээд оролцох эрхийг хязгаарлахгүй.

35 дугаар зүйл. Өрсөлдөөнт хэлэлцээний арга

35.1. Захиалагч дараах нөхцөл байдлын улмаас нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэх боломжгүй бол өрсөлдөөнт хэлэлцээний аргыг хэрэглэж болно:

35.1.1. Барааг ажил, үйлчилгээ яаралтай хэрэгцээтэй болсон бөгөөд энэхүү яаралтай нөхцөл байдлыг захиалагч урьдчилан мэдэх боломжгүй байсан, түүний үйл ажиллагаа удааширснаас шалтгаалаагүй байх;

35.1.2. Гамшиг ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон.

35.2. Өрсөлдөөнт хэлэлцээний аргаар тендер шалгаруулалт зохион байгуулахад захиалагч энэ хуулийн 54.7-д зааснаар хангалттай тооны аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ.

35.3. Өрсөлдөөнт хэлэлцээний аргаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, гэрээний үргэлжлэх хугацаа нь уг аргыг сонгох болсон яаралтай хэрэгцээг хангах тоо хэмжээ, хугацаагаар хязгаарлагдах ба түүнээс хэтэрсэн бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулна.

35.4. Захиалагч урилгад заасан хугацаанд хэлэлцээнд оролцох талаар мэдэгдсэн бүх сонирхогч этгээдийг оролцуулан хэлэлцээг нэгэн зэрэг хийх ба хэлэлцээний үйл явцад тэмдэглэл хөтөлнө.

35.5. Захиалагч худалдан авах ажиллагааны талаар аливаа мэдээлэл, зааварчилгаа, баримт, тодруулга, бусад мэдээллийг бүх сонирхогч этгээдэд ижил тэгш олгож, өрсөлдөх боломжоор хангана.

35.6. Захиалагч хэлэлцээ дууссаны дараа тендер шалгаруулалтын баримт бичгийг эцэслэн боловсруулж, цахим системд нийтлэх ба хэлэлцээнд оролцсон оролцогчдыг тендер ирүүлэхийг урина.

35.7. Өрсөлдөөнт хэлэлцээний аргаар хэлэлцээ хийх хугацааг урилга нийтэлснээс хойш ажлын 3-аас доошгүй хоног байхаар, тендер хүлээн авах эцсийн хугацааг хэлэлцээ дууссанаас хойш ажлын 5-аас доошгүй хоног байхаар тус тус заана.

35.8. Тендер хүлээн авснаас хойш тендер шалгаруулалттай холбоотой аливаа асуудлаар захиалагч, оролцогчтой хэлэлцээ хийхийг зөвшөөрөхгүй.

36 дугаар зүйл. Үнийн санал цахимаар дуудах арга

36.1. Захиалагч дараах нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тендер шалгаруулалтыг үнийн санал цахимаар дуудах аргаар зохион байгуулж болно:

36.1.1. цахим каталогт бүртгэгдсэн бараа, ажил, үйлчилгээ байх;

36.1.2. цахим системд бүртгэлтэй, захиалагчийн шаардсан чадавхын болон туршлагын шаардлага хангах аж ахуй эрхлэгчдийн дунд үнийн санал дуудаж, өрсөлдөөн нэмэгдэх боломжтой гэж үзсэн.

36.2. Захиалагч үнийн санал цахимаар дуудах урилгад энэ хуулийн 17.3-т зааснаас гадна дараах мэдээллийг тусгана:

36.2.1. үнийн санал цахимаар дуудах ажиллагаа хүчин төгөлдөр байх оролцогчдын тоо;

36.2.2. үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам, хугацаа.

36.3. Захиалагч энэ хуулийн 54.7-д зааснаар цахим системд бүртгэлтэй аж ахуй эрхлэгчдэд үнийн санал цахимаар дуудах урилга хүргүүлж, тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим системд нийтэлнэ.

36.4. Үнийн санал цахимаар дуудах ажиллагааг урилга хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 3-аас доошгүй хоногийн дараа зохион байгуулах ба үргэлжлэх хугацаа нь 1-2 цаг байхаар тогтооно.

36.5. Үнийн санал цахимаар дуудах ажиллагаанд оролцохоор бүртгүүлсэн бүх сонирхогч этгээдийг үнийн санал цахимаар дуудах ажиллагаанд оролцуулна. Хэрэв бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо энэ хуулийн 36.2.1-д заасан тоонд хүрээгүй бол үнийн санал цахимаар дуудах ажиллагааг цуцалж, энэ тухай бүртгүүлсэн оролцогчид нэн даруй цахим системээр мэдэгдэнэ.

36.6. Энэ хуулийн 36.5-д заасан үнийн санал цахимаар дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээд тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу бэлтгэсэн бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт, бусад шаардсан баримт бичгийг бүрдүүлсэн тендерийг цахим системд ирүүлнэ.

36.7. Үнийн санал цахимаар дуудах ажиллагааны туршид оролцогчийн хэн болохыг задруулахгүй бөгөөд оролцогч нь цахим системээс ирүүлсэн ялгах дугаарыг ашиглаж заасан хугацаанд үнийн саналыг хэдэн ч удаа ирүүлж болно.

36.8. Үнийн санал цахимаар дуудах ажиллагаа хаагдахад өсөх дарааллаар эрэмбэлэгдсэн үнийн саналаас хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үзэж, гэрээ байгуулах эрх олгоно.

36.9. Энэ хуулийн 36.8-д зааснаар эрэмбэлэхэд хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий тендер хоёр ба түүнээс олон байвал цахим системд хамгийн анх ирүүлсэн тендерийг сонгоно.

36.10. Цахим системийн үйл ажиллагаанд гарсан алдаанаас хамаарч үнийн санал дуудах ажиллагаа тасалдсан эсхүл уг ажиллагааг явуулахад эрсдэл үүсэх нөхцөл байдал байгаа гэж захиалагч эсхүл мэргэжлийн байгууллага үзсэн бол үнийн санал цахимаар дуудах ажиллагааг зогсоож, дуусгавар болгоно. Энэ тохиолдолд оролцогчийн мэдээллийг болон цахим системд ирүүлсэн тендерийг задруулахгүй.

37 дугаар зүйл. Нэг эх үүсвэрээс худалдан авах арга

37.1. Захиалагч зөвхөн дараах нөхцөлд нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж болно:

37.1.1. оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар бараа, ажил, үйлчилгээг зөвхөн оюуны өмчийн эрх эзэмшигчээс, эсхүл түүнээс

лицензийн гэрээний дагуу ашиглах эрх авсан зөвхөн албан ёсны нэг дистрибьютерээс худалдан авах, гүйцэтгүүлэх боломжтой бөгөөд тендер шалгаруулалтын бусад аргыг хэрэглэх боломжгүй бол;

37.1.2. онц байдал тогтоосон эсхүл гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбоотой бараа, ажил, үйлчилгээг худалдан авах нэн яаралтай хэрэгцээ бий болсон бөгөөд тендер шалгаруулалтын бусад аргыг хэрэглэх нь цаг хугацааны хувьд боломжгүй бол.

37.2. Энэ хуулийн 37.1.1-д заасан оюуны өмчийн эрхэд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд түүнийг орлуулах боломжгүй байхыг шаардана.

37.3. Нэг этгээдээс худалдан авах аргаар зохион байгуулахад тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа шаардахгүй байж болно.

38 дугаар зүйл. Ерөнхий гэрээ байгуулах арга

38.1. Ерөнхий гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр дараах хоёр үе шаттайгаар зохион байгуулна:

38.1.1. нэгдүгээр шатанд худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага захиалагчийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц сонирхогч этгээдийг сонгон шалгаруулж, ерөнхий гэрээг 5 хүртэл жилийн хугацаатай байгуулан, шалгарсан оролцогчийг цахим дэлгүүрт бүртгэх;

38.1.2. хоёрдугаар шатанд захиалагч цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 38.2-т заасан аргын аль тохирох аргад үндэслэн цахим дэлгүүрт бүртгэгдсэн оролцогчтой ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ байгуулах.

38.2. Захиалагч цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад дараах аргын аль тохирохыг хэрэглэнэ:

38.2.1. шууд сонгох;

38.2.2. үнийн санал цахимаар дуудах;

38.2.3. үнийн санал авах.

38.3. Ерөнхий гэрээ байгуулах оролцогчийн тоог хязгаарлахгүй ба захиалагч түүний хүчинтэй байх хугацаанд шалгуур, шаардлагыг хангасан сонирхогч этгээдийг нэмж оруулахаар ерөнхий гэрээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж болно.

38.4. Ерөнхий гэрээ байгуулах зарлалд энэ хуулийн 17.3-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг тусгана:

38.4.1. Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтын арга;

38.4.2. Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаа.

38.5. Ерөнхий гэрээ байгуулах нэгж үнэ нь татвар, даатгал, тээвэрлэлтийн болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг багтаасан байх бөгөөд цахим дэлгүүрт “нэгж үнэ”, “тээвэрлэлтийн зардлыг хассан нэгж үнэ” гэсэн сонголттойгоор байршуулна.

38.6. Ерөнхий гэрээний дагуу байгуулах худалдан авах гэрээ энэ хуулийн 38.2-т заасан аргын аль тохироход үндэслэн ерөнхий гэрээний нөхцөл шаардлагын дагуу хийгдэнэ.

38.7. Энэ хуулийн 38.2.1-д заасан шууд сонголтын аргыг хэрэглэхээс бусад нөхцөлд худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллага үнийн санал цахимаар дуудах, үнийн санал авах аргыг захиалагчаас цахим системээр ирүүлсэн захиалгын хуудаст үндэслэн, тус хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан хоёрдугаар шатны шалгаруулалтыг зохион байгуулна.

38.8. Хоёрдугаар шатны шалгаруулалтын үед захиалагч бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй.

38.9. Цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар нь тодорхой нөхцөлд захиалагч шууд сонголтын аргыг хэрэглэнэ.

38.10. Захиалагч шууд сонголтын аргын дагуу бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад цахим дэлгүүрт бүртгэгдсэн хамгийн бага үнийн санал бүхий иргэн, аж ахуй эрхлэгчээс сонгон, гэрээ байгуулах эрх олгоно.

38.11. Цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэгж үнийг бууруулах зорилгоор захиалагч үнийн санал цахимаар дуудах аргыг хэрэглэнэ.

38.12. Үнийн санал цахимаар дуудах ажиллагаанд оролцох урилгыг тухайн ерөнхий гэрээ байгуулсан аж ахуй эрхлэгч цахим системээр хүргүүлнэ.

38.13. Энэ хуулийн 38.12-т зааснаар үнийн санал цахимаар дуудах ажиллагааг урилга хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 3-аас доошгүй хоногийн дараа зохион байгуулах ба үргэлжлэх хугацаа нь 1-2 цаг байхаар тогтооно.

38.14. Үнийн санал цахимаар дуудах ажиллагаанд энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан үнийн саналыг үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох журмыг баримтална.

38.15. Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хүргэх газар, тоо хэмжээ, хамрах хүрээнд үндэслэн эцсийн үнэ авахад үнийн санал авах аргыг хэрэглэнэ.

38.16. Үнийн санал авах ажиллагаанд оролцох урилгыг тухайн ерөнхий гэрээ байгуулсан иргэн, аж ахуй эрхлэгчид цахим системээр хүргүүлж, үнийн санал авах эцсийн хугацааг урилга хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 3-аас доошгүй хоногоор тогтооно.

38.17. Үнийн санал авах ажиллагаанд үнэ болон үнийн бус шалгуур болох ажил, үйлчилгээний хуваарь, бараа нийлүүлэлтийн хуваарь, хүргэлтийн нөхцөл зэргийг харгалзан захиалагчийн захиалгад хамгийн сайн нийцэх үнийн санал ирүүлсэн иргэн, аж ахуй эрхлэгчийг сонгон, гэрээ байгуулах эрх олгоно.

38.18. Үнийн санал цахимаар дуудах, үнийн санал авах ажиллагаанд үнийн санал ирээгүй бол захиалагч шууд сонголтын аргыг ашиглан, гэрээ байгуулах эрх олгож болно.

38.19. Ерөнхий гэрээ байгуулах журам, зааврыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38.20. Ерөнхий гэрээнд заасан үүрэг гүйцэтгээгүй оролцогчийг ерөнхий гэрээний гүйцэтгэгчээс хасаж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

39 дүгээр зүйл. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ

39.1. Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ (цаашид “худалдан авах гэрээ” гэх)-тэй холбоотой харилцааг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна.

39.2. Тендер шалгаруулалтын баримт бичиг болон хамгийн сайн үнэлэгдсэн тендерийн техникийн болон худалдааны нөхцөл нь худалдан авах гэрээний үндсэн нөхцөл болно.

39.3. Энэ хуулийн 29.7-д заасны дагуу захиалагч хамгийн сайн үнэлэгдсэн тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсэн бол уг үнийг гэрээний үнээр тогтооно.

39.4. Энэ хуулийн 39.2, 39.3-ыг баримтлан худалдан авах гэрээний нөхцөлийг тодорхойлоход дараах нөхцөлийг тусгана:

39.4.1. гэрээний үнэ;

39.4.2. төлбөр хийх нөхцөл, хэлбэр;

39.4.3. урьдчилгаа төлбөр хийх бол урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн, хэлбэр;

39.4.4. гэрээний зүйл буюу бараа, ажил, үйлчилгээний тухай тодорхой мэдээлэл;

39.4.5. захиалагчийн хяналт болон бусад нөхцөл;

39.4.6. урьдчилгаа төлбөр олгох бол урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн;

39.4.7. гүйцэтгэлийн баталгаа шаардах бол түүний дүн;

39.4.8. худалдааны нөхцөлүүд;

39.4.9. бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх хуваарь;

39.4.10. давуу эрх тооцсон бол давуу эрх тооцсон бараа, материал, ажиллах хүчийг гэрээний үүрэг гүйцэтгэхэд хэрэглэх мэдээлэл;

39.4.11. гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал;

39.4.12. баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа;

39.4.13. гэрээний үүргийг туслан гүйцэтгүүлэх бол туслан гүйцэтгэгч ажиллуулах журам;

39.4.14. гэрээ цуцлах болон гэрээнээс татгалзах үндэслэл, журам.

39.5. Засгийн газрын гишүүний баталсан стандарт нөхцөл нь ерөнхий болон тусгай нөхцөлөөс бүрдэх бөгөөд ерөнхий нөхцөлд захиалагч аливаа өөрчлөлт оруулахгүй.

40 дүгээр зүйл. Гэрээний үүргийг туслан гүйцэтгүүлэх

40.1. Хамгийн сайн үнэлэгдсэн тендерт энэ хуулийн 7.3-т нийцүүлэн гэрээний үүргийн тодорхой хэсгийг туслан гүйцэтгүүлэхээр заасан бол туслан гүйцэтгүүлэх үүргийн хэмжээ нь тендерт тусгасан дүнгээс хэтрэхгүй байна.

40.2. Гэрээний үүргийг гүйцэтгэхтэй холбоотойгоор тендерт санал болгосон туслан гүйцэтгэгчийг солих, эсхүл шинээр туслан гүйцэтгэгч оролцуулах бол оролцогч энэ тухай хүсэлтийг холбогдох мэдээллийн хамт захиалагчид хүргүүлнэ.

40.3. Оролцогчийн санал болгосон туслан гүйцэтгүүлэх үүргийн хэмжээ тендерт санал болгосон үнийн дүнгээс хэтрэхгүй бөгөөд санал болгосон туслан гүйцэтгэгч тухайн үүргийг гүйцэтгэх чадавх, туршлагатай тохиолдолд захиалагч туслан гүйцэтгэгч ажиллуулах зөвшөөрлийг олгох ба зөвшөөрөл олгохоос үндэслэлгүй татгалзахгүй.

40.4. Туслан гүйцэтгэгч ажиллуулах нь оролцогчийг гэрээний үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

41 дүгээр зүйл. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглох

41.1. Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараахаас бусад тохиолдолд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах хориглоно:

41.1.1. Захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах;

41.1.2. Энэ хуулийн 41.2-т зааснаас бусад үндэслэлээр гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх;

41.1.3. Энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасан туслан гүйцэтгэгч ажиллуулах журмыг зөрчсөн.

41.2. Нэг эх үүсвэрээс худалдан авахаас бусад аргаар сонгон шалгаруулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөн шалтгаанаар төсөвт өртгийг хуулиар өөрчлөн баталсан бол талууд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчилж болно.

41.3. Гүйцэтгэгч гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

41.4. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулсны улмаас гүйцэтгэгчийн эрх үүргийг залгамжлан авах нь энэ хуулийн 41.2-т заасныг зөрчсөн тооцогдохгүй боловч эрх залгамжлан авсан этгээдтэй холбоотойгоор энэ хуулийн 6.1.1, 6.1.4, 6.1.6, 6.1.8, 6.1.9-д заасан нөхцөл бий болсон эсхүл гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон бол гүйцэтгэгчийг гэрээний үүрэг зөрчсөн гэж үзэж гэрээг цуцална.

42 дугаар зүйл. Хүчин төгөлдөр бус гэрээ

42.1. Дараах нөхцөл байдлын үндсэн дээр байгуулсан худалдан авах гэрээ хүчин төгөлдөр бус байна:

42.1.1. Тендер шалгаруулалтын аргыг буруу хэрэглэсэн;

42.1.2. Тендер шалгаруулалтын зарлал нийтлэх, урилга хүргүүлэхэд ил тод байдлыг хангаагүй;

42.1.3. энэ хуулийн 27-29 дүгээр зүйлийн дагуу тендер хянан үзэх, үнэлэх шатанд гаргасан алдаа нь гэрээ байгуулах эрхийг буруу оролцогчид олгоход хүргэсэн;

42.1.4. тендер хүлээн авах эцсийн хугацаа болон энэ хуулийн 31.2-т заасан гомдол гаргах боломжтой хугацааг баримтлаагүй, эсхүл энэ хуулийн 26.3, 26.4-т зааснаар гэрээ байгуулах эрх авсан оролцогчийн тендертэй танилцах эрхийг хязгаарласан;

42.1.5. энэ хуулийн 41 дүгээр зүйлийг зөрчиж оруулсан нэмэлт, өөрчлөлт.

42.2. Худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бус болохыг худалдан авах ажиллагааны улсын байцаагч болон шүүх тогтоож болно.

42.3. Шүүх худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бус болохыг тогтоосон бөгөөд тухайн гэрээний үйлчлэлийг шууд дуусгавар болгох нь нийтийн ашиг сонирхолд хохиролтой гэж үзвэл захиалагчийг дараагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах хүртэл хугацаанд гэрээний үүрэг гүйцэтгүүлэх журмыг шүүх тогтоож болно.

43 дугаар зүйл. Гүйцэтгэлийн баталгаа

43.1. Захиалагч 200 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, эсхүл ерөнхий гэрээнээс бусад гэрээ хоёр жил ба

түүнээс дээш хугацаагаар үргэлжлэх бол гэрээ байгуулах эрх авсан оролцогчоос гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах гүйцэтгэлийн баталгаа шаардана.

43.2. Захиалагч гэрээний үнийн дүнгийн 5 хувиар гүйцэтгэлийн баталгаа шаардах тухай тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

43.3. Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг дараах хэлбэрээр ирүүлж болно:

43.3.1. энэ хуулийн 43.2-т заасан дүнгээс багагүй мөнгөн төлбөрийн үүргийг захиалагчийн шаардлагаар гүйцэтгэх тухай банкны, эсхүл Төрийн сангийн баталгаа;

43.3.2. энэ хуулийн 43.2-т заасан дүнгээс багагүй нэрлэсэн үнэтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг захиалагчийн шаардлагаар шилжүүлэх тухай эрх бүхий этгээдийн баталгаа.

43.4. Гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах эрхийг зөвхөн гадаадын этгээд эдлэх бөгөөд энэ тохиолдолд баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдээр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагыг тодорхой заасан байна.

43.5. Худалдан авах гэрээний гүйцэтгэл хоёр жилээс дээш хугацаагаар үргэлжлэх бол захиалагч гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн үүргийн хэмжээтэй хувь тэнцүүлэн гүйцэтгэлийн баталгааны дүнг бууруулахаар гэрээнд зааж болно.

43.6. Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал саатуулан барих нөхцөлийг захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.

43.7. Гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааны үнийн дүнг гадаад валютаар илэрхийлэх бол баталгаа гаргасан өдрийн өмнөх өдрийн Монголбанкны албан ханшаар тодорхойлно.

43.8. Энэ хуулийн 41.1-41.4-т зааснаар гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсхүл гэрээний хүчинтэй хугацаанд гүйцэтгэлийн баталгаа хүчингүй болох нөхцөл үүсвэл гүйцэтгэгч баталгааг зохих шаардлагад нийцүүлэн шинэчлэн гаргуулах, хүчинтэй гүйцэтгэлийн баталгаагаар солих үүрэг хүлээнэ.

44 дүгээр зүйл. Урьдчилгаа төлбөр, түүний баталгаа

44.1. Тендер шалгаруулалтын баримт бичигт зөвшөөрсний дагуу ажил гүйцэтгэх гэрээний бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлөх бол урьдчилгаа төлбөрийг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулахыг баталгаажуулж, урьдчилгаа төлбөрийн дүнгээс багагүй дүнтэй баталгаа шаардана.

44.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт заагаагүй, эсхүл хүчин төгөлдөр урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно.

44.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнд энэ хуулийн 43 дугаар зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгааны дүнг оруулан тооцож болно.

44.4. Урьдчилгаа төлбөрийн баталгааг энэ хуулийн 43.3, 43.4-т заасан хэлбэрээр гаргуулж болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА

45 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааг төлөвлөх

45.1. Захиалагч дараа оны төсвийн төсөлд үндэслэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, цахим системд бүртгэнэ.

45.2. Захиалагч төсвийн төсөлд тусгасан тоо хэмжээгээр ерөнхий гэрээ байгуулах саналыг боловсруулж, худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

45.3. Энэ хуулийн 45.2-т заасны дагуу ерөнхий гэрээнд хамруулах судалгааг 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор хийж, тендер шалгаруулалтыг 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулна.

45.4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг энэ хуулийн 45.5-45.9-д заасан шатлалаар боловсруулан батлуулна.

45.5. Захиалагч төрийн байгууллага, албан газар, төрийн болон орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газрын төсвийн шууд захирагч, гүйцэтгэх удирдлага нь төлөвлөгөө, тайланг баталж, дараах үе шатаар холбогдох дээд шатны байгууллагад цахим системээр ирүүлнэ:

45.5.1. төсвийн шууд захирагч нь төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчийн төлөвлөгөөг нэгтгэн төсвийн ерөнхийлөн захирагчид;

45.5.2. төсвийн төвлөрүүлэн захирагчгүй бол төсвийн шууд захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчид;

45.5.3. Төсвийн тухай хуулийн 61.1-д заасны дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний үндсэн дээр санхүүжих байгууллагын төсвийн шууд захирагч нь сум, дүүргийн Засаг даргад, сум, дүүргийн Засаг дарга нь төсвийн шууд захирагчийн төлөвлөгөөг тайланг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн төлөвлөгөөг нэгтгэн холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагчид;

45.5.4. төсвийн ерөнхийлөн захирагч нь дээрх төсвийн захирагчдын төлөвлөгөөг төсөв баталснаас хойш ажлын 10 хоногт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад.

45.6. Захиалагч төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага нь өөрийн байгууллагын төлөвлөгөө, тайланг баталж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөвлөгөө, тайланг нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нэгтгэсэн төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөвлөгөө, тайланг нэгтгэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр ирүүлнэ.

45.7. Захиалагч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага нь өөрийн байгууллагын төлөвлөгөө, тайланг баталж, дараах үе шатаар холбогдох дээд шатны байгууллагад цахим системээр ирүүлнэ:

45.7.1. сум, дүүрэгт харьяалагдах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага нь сум, дүүргийн Засаг даргад, сум, дүүргийн Засаг дарга нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөвлөгөө, тайланг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад;

45.7.2. аймаг, нийслэлд харьяалагдах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага аймаг, нийслэлийн Засаг даргад;

45.7.3. аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөвлөгөө, тайланг нэгтгэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад.

45.8. Захиалагч төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх удирдлага нь өөрийн байгууллагын төлөвлөгөө, тайланг баталж төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээдэд, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн төлөвлөгөө, тайланг нэгтгэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр ирүүлнэ.

45.9. Захиалагч төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төслийн зохицуулагч нь өөрийн байгууллагын төлөвлөгөө, тайланг баталж төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчид, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөвлөгөө, тайланг нэгтгэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр ирүүлнэ.

45.10. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуулийн 45.4-т заасны дагуу ирүүлсэн төлөвлөгөөг хүлээж авч, цахим системд нийтэлнэ.

45.11. Төсвийн ерөнхийлөн захирагч болон холбогдох бусад этгээд нь энэ хуулийн 45.5-45.9-д заасны дагуу ирүүлсэн төлөвлөгөөг хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ.

45.12. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагч болон холбогдох бусад этгээдээс ирүүлсэн төлөвлөгөөг хянаж, худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн төлөвлөгөөтэй тулгаж баталгаажуулна.

45.13. Төсөвт тодотгол орсноос бусад тохиолдолд тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

45.14. Төсвийн жил дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгай тэмдэглэгээний хамт тусгана.

46 дугаар зүйл. Худалдан авах ажиллагаа зохион байгуулах

46.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

46.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн захиргааны төв болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллага, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, тусгай шилжүүлгийн байгууллага, энэ хуулийн 3.1.8.1, 3.1.8.2-д заасан захиалагч нь өөрийн хэрэгцээнд худалдан авах бүх бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна.

46.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутагт хэрэгжих худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна.

46.4. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь өөрийн төсвийн хүрээнд захиалагч байна.

46.5. Захиалагчийн өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ байнгын шаардлагатай бол гэрээний үргэлжлэх хугацаа 2-4 жил хүртэл хугацаагаар байж болно.

46.6. Захиалагч өөрийн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд шаардагдах нийтлэг үйлчилгээний гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг 3 хүртэл жилээр байгуулж болно.

46.7. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь ерөнхий гэрээ, улсын болон бүс нутгийн чанартай томоохон хэмжээний худалдан авах ажиллагааны хувьд захиалагч байна.

46.8. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргад энэ хуулийн 46.3-т заасан эрхээ шилжүүлж болно.

46.9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг зохион байгуулах этгээдийн жагсаалтыг Засгийн газрын тогтоолоор батална.

47 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааг тайлагнах

47.1. Захиалагч худалдан авах ажиллагааны явцыг цахим системд хөтөлж, тайланг төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ болгоноор бүрэн тайлагнана.

47.2. Захиалагч энэ хуулийн 45.5-45.9-д заасан шатлалын дагуу батлуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мөн шатлалын дагуу тухайн онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нэг бүрээр тайлагнана.

47.3. Энэ хуулийн 47.2-т заасан худалдан авах ажиллагааны тайланг төсвийн ерөнхийлөн захирагч болон холбогдох бусад этгээд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

47.4. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн тайланг нэгтгэн Засгийн газрын хуралд эхний улиралд багтаан танилцуулж, төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгдсэн дүнг тусгана.

48 дугаар зүйл. Тендер шалгаруулалтыг хамтран зохион байгуулах

48.1. Энэ хуульд заасан хоёр ба түүнээс дээш тооны захиалагч тус бүрийн төсөв, хөрөнгийн хүрээнд тодорхой зорилгыг хамтран хэрэгжүүлэх, эсхүл ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг хамтран зохион байгуулах нь худалдан авах ажиллагаанд өрсөлдөөнийг нэмэгдүүлэх давуу талтай гэж үзвэл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагаар дамжуулан тендер шалгаруулалтыг хамтран зохион байгуулж болно.

48.2. Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах захиалагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд энэ хуульд заасан захиалагчийн эрх, үүргийг хүлээнэ.

49 дүгээр зүйл. Захиалагчийн эрх, үүрэг

49.1. Захиалагч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

49.1.1. хуулийн 46.1-д заасан худалдан авах ажиллагааг энэ хуульд заасны журмын дагуу зохион байгуулах;

49.1.2. хуулийн 46.8-д заасан худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;

49.1.3. тендер шалгаруулалтад хяналт тавих, шалгарсан оролцогчид гэрээ байгуулах эрх олгох;

49.1.4. гэрээ байгуулах эрх авсан оролцогчтой худалдан авах гэрээ байгуулах;

49.1.5. Энэ хуулийн 49.1.3-т заасны дагуу байгуулсан гэрээнд хяналт тавих, хууль болон гэрээнд заасан зорилго, нөхцөл бүрэн хэрэгжиж байгаа эсэхэд тогтмол удирдлагаар хангах;

49.1.6. хуулийн 49.1.4-т заасны дагуу гэрээний хэрэгжилтийг цахим системд тогтмол нийтлэх;

49.1.7. хуулийн 49.1.4-т заасны дагуу байгуулсан гүйцэтгэгчийн дэлгэрэнгүй мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид байрлуулахыг шаардах;

49.1.8. ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг алслагдсан сум, орон нутагт гүйцэтгэхээс бусад тохиолдолд цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс тухайн бараа, үйлчилгээг худалдан авахгүй байх.

49.2. Аймаг, дүүрэг, нийслэлийн төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг энэ хуулийн 57.1-д заасан худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын орон нутаг дахь нэгж зохион байгуулна.

49.3. Захиалагч энэ хуулийн 6.1.4-т заасан өөрийн хараат үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн сүүлийн 3-аас доошгүй жилийн үйл ажиллагааны борлуулалтын орлогын 80-аас дээш хувь нь тухайн захиалагчийн даалгасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь зөвхөн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөс бүрддэг ба аливаа бусад иргэн, хуулийн этгээдэд ногдол ашиг, ашиг олгодоггүй тохиолдолд тухайн хуулийн этгээдтэй тодорхой бараа нийлүүлэх, ажил гүйцэтгүүлэх, эсхүл үйлчилгээ авахаар даалгах гэрээ байгуулж болно.

49.4. Энэ хуулийн 49.3-т зааснаар гэрээ байгуулсан хуулийн этгээд нь бараа, ажил, үйлчилгээтэй гүйцэтгэхтэй холбоотойгоор худалдан авах ажиллагаа зохион байгуулахад энэ хуулийг баримтлах үүргээс чөлөөлөгдөхгүй.

49.5. Энэ хуулийн 49.3-т зааснаар төсөл, арга хэмжээ гүйцэтгэх хуулийн этгээд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг энэ хуульд заасны дагуу төлөвлөж, зохион байгуулж, тайлагнана.

50 дугаар зүйл. Үнэлгээний хороо

50.1. Захиалагч энэ хуулийн дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад үнэлгээний хороо байгуулна.

50.2. Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна:

50.2.1. тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх;

50.2.2. тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, захиалагчийн шийдвэрийн зөвлөмж боловсруулах.

50.3. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд 53.2-т зааснаар мэдээллийн санд бүртгэлтэй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах эрх хязгаарлаагүй 3-аас доошгүй сондгой тооны худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтныг томилно.

50.4. Үнэлгээний хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус, хөндлөнгийн гишүүн байна.

50.5. Энэ хуулийн 50.4-т заасан хөндлөнгийн гишүүнийг тухайн салбарын холбоо, төрийн бус байгууллага болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас тухайн худалдан авах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилгүй гэж тодорхойлсон хувийн хэвшлийн төлөөллөөс сонгоно.

50.6. Нийслэл хотоос бусад орон нутаг дахь захиалагчийн зохион байгуулж буй тендер шалгаруулалтад энэ хуулийн 50.5-д зааснаар төлөөлөл оролцуулах боломжтой холбоо, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл байхгүй бол энэ хуулийн 50.7-д заасан журмаар хөтлөх жагсаалтад нэр орсон иргэнийг үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүнээр томилно.

50.7. Төрийн албан хаагч бус, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны эрхтэй иргэн үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүнээр ажиллах иргэний жагсаалтад бүртгүүлэх хүсэлтээ аймаг, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд гаргах эрхтэй.

50.8. Энэ хуулийн 50.7-д заасан шаардлагыг хангасан иргэний хүсэлтийг хүлээн авсан аймаг, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба ажлын 10 хоногийн дотор тухайн аймаг, дүүргийн худалдан авах ажиллагаанд хөндлөнгийн гишүүнээр ажиллах иргэний жагсаалтад бүртгэж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

50.9. Энэ хуулийн 50.7-д заасан жагсаалтад орсон иргэн төрийн албан хаагчаар ажиллаагүй хугацаанд өөрийн ажил олгогчоос бусад захиалагч байгууллагын үнэлгээний хороонд хөндлөнгийн гишүүнээр ажиллах эрхтэй.

50.10. Үнэлгээний хорооны гишүүн хүндэтгэх үзэх шалтгаанаар үргэлжлүүлэх ажиллах боломжгүй болсон, энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан үүрэг зөрчсөн бол захиалагч түүнийг үнэлгээний хорооны гишүүний үүргээс чөлөөлж, шинэ гишүүн нөхөн томилно.

50.11. Захиалагч үнэлгээний хорооны хараат бус, бие даасан байдлыг хангах зорилгоор энэ хуулийн 50.2.1-д заасан чиг үүргийг гүйцэтгэснээр үнэлгээний хорооны чиг үүрэг дуусгавар болохоор байгуулж болно.

50.12. Энэ хуулийн 50.11-д заасан тохиолдолд тендер нээсэн даруйд дараагийн үнэлгээний хорооны гишүүд энэ хуулийн 50.2.2-т заасан чиг үүргийг гүйцэтгэж эхлэх боломжтой байдлаар захиалагч шинэ үнэлгээний хороог тендерийн нээлтээс өмнө, эсхүл тендер нээсэн даруйд байгуулна.

50.13. Үнэлгээний хорооны дарга үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, үнэлгээний хорооны хурлыг товлох, үнэлгээний хороо тогтоосон хугацаанд түргэн шуурхай шийдвэр гаргаж, захиалагчид хүргүүлэх, үнэлгээний хороог захиалагчийн өмнө төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

51 дүгээр зүйл. Үнэлгээний хорооны хурал

51.1. Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хурал байна.

51.2. Энэ хуулийн 50.12-т зааснаар тендер нээх өдөр шинэ үнэлгээний хороо байгуулснаас бусад тохиолдолд үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ.

51.3. Энэ хуульд заасан үндэслэлээр холбогдох этгээдээс тайлбар, тодруулга авах шаардлагатай бол тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг завсарлуулж болно.

51.4. Хууль тогтоомжид заасан үндэслэлээр эрх бүхий байгууллагаас тогтоосон бэлэн байдлын зэрэг, хорио цээр, хязгаарлалтын дэглэм болон бусад адилтгах нөхцөл байдлаас шалтгаалан үнэлгээний хорооны бүх эсхүл зарим гишүүд биечлэн хуралд оролцох боломжгүй бол тухайн гишүүдийг хуралд цахим хэлбэрээр оролцуулж болно.

51.5. Үнэлгээний хорооны хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх ба энэ хуулийн 30.1-д заасан шийдвэр гаргах зөвлөмж бүхий дүгнэлтийг үнэлгээний хорооны нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

51.6. Энэ хуулийн 51.5-д заасан шийдвэр гаргах зөвлөмж бүхий дүгнэлтийг үнэлгээний хорооны гишүүд хуралд оролцсон эсэхээс үл хамааран танилцаж, дүгнэлтийг дэмжих эсэх саналаа тусгаж баталгаажуулах үүрэгтэй.

52 дугаар зүйл. Худалдан авах ажиллагаанд оролцох ажилтан, албан тушаалтны үүрэг

52.1. Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тендер хянан үзэх, үнэлэх, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн бол мэдэгдэх, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх үүрэг хүлээнэ.

52.2. Энэ хуулийн 52.1-д заасан албан тушаалтан, ажилтан энэ хуульд зааснаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох үүргээ цаг тухайд нь гүйцэтгэх, энэ хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаар хуульд тусгайлан заагаагүй асуудлаар шийдвэр гаргахад энэ хуулийн -д заасан зарчмыг баримтална.

52.3. Захиалагч, түүнийг төлөөлөх аливаа этгээд худалдан авах ажиллагаанд холбогдох асуудлаар сонирхогч этгээд, оролцогч, тэдгээрийн төлөөлөлтэй зөвхөн бичгээр харилцах ба энэ хуульд зааснаас бусад үндэслэл, журмаар сонирхогч этгээд, оролцогч болон тэдгээрийг төлөөлж буй аливаа этгээдтэй уулзах, шууд болон шууд бусаар холбоо тогтоохыг хориглоно.

52.4. Энэ хуулийн 52.1-д заасан этгээд дараах үүргээ хэрэгжүүлээгүй нь түүнийг тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой чиг үүргээс чөлөөлөх, хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно:

52.4.1. ашиг сонирхлын зөрчлөө мэдэгдэх ёстой байсан боловч мэдэгдээгүй, эсхүл худал мэдүүлсэн;

52.4.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар худалдан авах ажиллагаанд холбогдох чиг үүргээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдээгүй, санал болгосон бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлын талаар хуульд заасан арга хэмжээ аваагүй.

52.5. Захиалагч энэ хуулийн 52.4-т заасан зөрчил гаргасан мэргэшсэн ажилтны мэдээллийг худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, энэ хуулийн 56.5-т заасан нөхцөл байдал илэрсэн оролцогчийн талаар мэдээллийг худалдан авах ажиллагааны улсын байцаагчид тус тус холбогдох нотлох баримтын хамт хүргүүлэх үүрэгтэй.

53 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан

53.1. Худалдан авах ажиллагааны хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулах дүрмийн зорилт бүхий иргэний нийгмийн байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон шаардлагыг хангаж, эрх авсны үндсэн дээр худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулж болно.

53.2. Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохих сургалтад хамрагдсан иргэнээс худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээ олгох шалгалт авах ба бүртгэлтэй мэргэшсэн ажилтны бүртгэлийг хөтөлж, цахим системд олон нийтэд нээлттэй байршуулна.

53.3. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтын байгууллага, түүний багш, ажилтанд тавигдах шаардлага, мэргэшсэн ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр болон мэргэшсэн ажилтны эрх олгох шалгалтын агуулгыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

53.4. Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 52.5-д зааснаар мэргэшсэн ажилтны зөрчлийн мэдээллийг хүлээн авсан бол мэргэшсэн ажилтны эрхийг 1 жилийн хугацаанд түдгэлзүүлж, холбогдох бүртгэлд өөрчлөлт оруулна.

54 дүгээр зүйл. Бүртгэлийн тогтолцоо

54.1. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд цахим системд бүртгүүлж, тус системд холбогдсон төрийн эрх бүхий байгууллагын мэдээллийн сангаас түүний мэдээллийг цахим системд тогтмол дамжуулахыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр тендер шалгаруулалтад оролцоно.

54.2. Цахим системд бүртгэлтэй иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага, 14-16 дугаар зүйлд заасан чадавх, туршлагыг хангах талаар мэдээлэл, баримт бичгийг оруулан, өөрийн хувийн хаягийг үүсгэж болно.

54.3. Иргэн, аж ахуйн нэгж энэ хуульд заасан захиалагчтай байгуулсан гэрээний үүргийн гүйцэтгэлийн талаар хувийн хаягтаа оруулсан мэдээллийн талаар захиалагч цахим системээр баталгаажуулна.

54.4. Энэ хуулийн 54.3-т зааснаар баталгаажуулсан гэрээний үүргийн гүйцэтгэлийн мэдээллийг бусад захиалагч үнэн зөв гэж тооцох бөгөөд үүргийн гүйцэтгэлийг нотлох талаар оролцогч нэмэлт мэдээлэл, баримт бичиг ирүүлэх шаардлагагүй.

54.5. Цахим системд бүртгэлтэй иргэн, хуулийн этгээд өөрийн хувийн хаягийн мэдээллийг тогтмол шинэчлэх үүрэгтэй ба мэдээллийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

54.6. Захиалагч энэ хуулийн 33.4-т зааснаар хүргүүлэх урилгыг тухайн салбарын тендер шалгаруулалтад оролцохоор бүртгүүлсэн аж ахуй эрхлэгчдэд ямар нэг ялгаваргүйгээр, нэгэн зэрэг илгээнэ.

54.7. Энэ хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын аргын дагуу хүргүүлэх урилгыг тухайн тендер шалгаруулалтын баримт бичигт заасан чадавхын болон туршлагыг хангана гэж бүртгүүлсэн бүх иргэн, аж ахуйн нэгжид нэгжид ямар нэг ялгаваргүйгээр, нэгэн зэрэг илгээнэ.

54.8. Цахим системд бүртгүүлэх, оролцогчийн чадавхыг цахим системээр магадлахтай холбоотой нарийвчилсан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

55 дугаар зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

55.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагааны талаар төрөөс хэрэгжүүлэх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

55.1.1. худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах;

55.1.2. худалдан авах ажиллагаатай холбоотой мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр захиалагчийг хангах;

55.1.3. худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичиг, тендер шалгаруулалтыг цахим системээр зохион байгуулахтай холбоотой журам, аргачлал, зааврыг батлах;

55.1.4. худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам, холбогдох маягыг батлах;

55.1.5. үнэлгээний хорооны бүтэц, зохион байгуулалт, урамшууллыг зохицуулах журмыг батлах;

55.1.6. захиалагч худалдан авах ажиллагаанд зохих журам, тендер шалгаруулалтын аргыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээ хийх;

55.1.7. захиалагчийн ирүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн, улсын хэмжээний худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн сан бүрдүүлэн хөтлөх, нэгдсэн тоо баримт, мэдээлэл гаргах;

55.1.8. оролцогч цахим системд бүртгүүлэх, оролцогчийн чадавхыг цахим системээр магадлахтай холбоотой нарийвчилсан журмыг батлах;

55.1.9. худалдан авах ажиллагааны чиглэлээр явагдах сургалтын түвшин, чанар, стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтоох, сургалтыг зохион байгуулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг зохион байгуулах журмыг батлах;

55.1.10. худалдан авах ажиллагааны асуудлаар олон улсын байгууллага, гадаад улсын бусад байгууллагатай хамтран ажиллах, энэ чиглэлээр олгосон техник туслалцааг төлөвлөх, зохицуулах;

55.1.11. энэ хуулийн 56.6-д заасан ерөнхий шаардлага хангахгүй этгээдийн жагсаалт хөтлөх, хяналт тавих, мэдээлэх;

55.1.12. хуульд заасан бүрэн эрх.

55.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагааны бодлого хариуцсан нэгжтэй байна.

56 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны улсын байцаагч

56.1. Энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий улсын байцаагч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байна. Улсын байцаагч нь улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч гэсэн ангилалтай байна.

56.2. Худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

56.3. Худалдан авах ажиллагааны улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг улсын ерөнхий байцаагч олгох, түдгэлзүүлэх, чөлөөлөх шийдвэр гаргана.

56.4. Улсын ерөнхий байцаагч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын худалдан авах ажиллагаа хариуцсан газар, хэлтсийн дарга нарт улсын ахлах байцаагчийн эрхийг, төрийн албанд гурваас доошгүй жил ажилласан, төрийн хяналт шалгалтын зохих туршлагатай төрийн албан хаагчид улсын байцаагчийн эрхийг олгож болно.

56.5. Худалдан авах ажиллагааны улсын байцаагч бусад этгээдийн хүсэлтээр болон хяналт шалгалтын хүрээнд илэрсэн дараах нөхцлийн тухай дүгнэлтийг гаргана:

56.5.1. сүүлийн 1 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцоход оролцогчийн чадавхын шаардлага, туршлагыг хангах тухай нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн, эсхүл засварласан;

56.5.2. сүүлийн 1 жилийн хугацаанд оролцогч энэ хуулийн 6.1.7-6.1.8-д заасан нөхцөл, ашиг сонирхлын зөрчлийн талаар худал мэдүүлсэн;

56.5.3. сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах гэрээний үүргээ гүйцэтгээгүй, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүй шалтгаанаар гэрээ цуцлагдсан, эсхүл захиалагч хохирол шаардсан;

56.5.4. сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эсхүл эрх бүхий бусад этгээд тогтоосон.

56.6. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 56.5-д заасан дүгнэлтэд үндэслэн иргэн, аж ахуй эрхлэгчийг ерөнхий шаардлага хангахгүй этгээдийн жагсаалтад бүртгэнэ.

56.7. Худалдан авах ажиллагааны улсын байцаагч энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавихдаа Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

56.7.1. энэ хуулийн 56.5-т зааснаар ерөнхий нөхцөл хангахгүй оролцогчийн бүртгэлд хамруулах санал гаргах;

56.7.2. энэ хуульд заасан үүргээ зөрчсөн ажилтан, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

56.7.3. энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан хүчин төгөлдөр бус гэрээг тогтоох;

56.7.4. гэрээний үүргийн гүйцэтгэлд гарсан алдааг залруулахыг шаардах.

56.8. Энэ хуулийн 56.7.2, 56.7.3, 56.7.4-т зааснаар худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн гаргасан санал, дүгнэлтийг холбогдох эрх бүхий албан тушаалтан, байгууллагад хүргүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор биелэлтийн талаар хариу мэдэгдэнэ.

56.9. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 56.7.1-д заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор тушаал гаргаж, гэрээ байгуулах ерөнхий нөхцөл хангахгүй этгээдийн жагсаалтыг хөтөлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

56.10. Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн энэ хуулийн 56.7.1-д заасан шийдвэртэй холбогдох гомдлыг ажлын 10 хоногийн дотор, бусад шийдвэртэй холбогдох гомдлыг 20 хоногийн дотор тус тус улсын ерөнхий байцаагчид гаргана.

56.11. Худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагч гомдлыг ажлын 20 хоногийн дотор шийдвэрлэнэ.

56.12. Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрмийг Засгийн газар батална.

57 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага

57.1. Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэх ба аймаг, дүүрэг, нийслэлийн Засаг даргын дэргэд харьяа нэгжтэй байна.

57.2. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага энэ хуульд зааснаар эрх олгосон худалдан авах ажиллагааг зохион байгуулах, ерөнхий гэрээ байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

57.3. Аймаг, дүүрэг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг тухайн аймаг, дүүрэг, нийслэлийн Засаг дарга худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

57.4. Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь нэгжийн дарга нь ял шийтгэлгүй, төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс худалдан авах ажиллагааны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байна.

57.5. Аймаг, дүүрэг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг дарга худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын орон нутаг дахь нэгжийн хэвийн, хараат бус үйл явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

57.6. Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуульд заасан захиалагчийн эрх, үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

57.6.1. худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

57.6.2. худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах;

57.6.3. худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

57.6.4. худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх цахим хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох, боловсронгуй болгох;

57.6.5. захиалагч болон тендерт оролцогчдыг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тэдэнд сургалт зохион байгуулах;

57.6.6. худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чадавх, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;

57.6.7. энэ хуулийн 3.1.7-д заасан ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

57.6.8. цахим системийн үйл ажиллагааг хариуцан, цахим системийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах

57.6.9. энэ хуулийн 54 дугаар зүйлд заасан бүртгэлийг хариуцан зохион байгуулж, иргэн, аж ахуй эрхлэгчийн цахим мэдээллийн сан үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэх;

57.6.10. мэдээллийн сангийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах замаар мэдээллийн сангийн үнэн зөв, бодит байдлыг хангах;

57.6.11. улсын хэмжээний худалдан авах ажиллагааны талаарх мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлэх;

57.6.12. орон нутаг дахь салбар нэгжийн болон бусад захиалагч байгууллагын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан, албан хаагчийг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

57.6.13. бараа, ажил, үйлчилгээний жишиг техникийн тодорхойлолт боловсруулах, ерөнхий гэрээ байгуулах бараа, ажил, үйлчилгээг тодорхойлох зорилгоор зах зээлийн судалгаа хийх;

57.6.14. худалдан авах ажиллагааны үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан бусад чиг үүрэг.

57.7. Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

57.8. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын орон нутаг дахь нэгж дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

57.8.1. орон нутгийн чанартай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг захиалагчаас эрх олгогдсоны үндсэн дээр зохион байгуулж, энэ хуулийн 49.1.1-49.1.3-д заасан эрх, үүргийг эдлэх;

57.8.2. улсын хэмжээнд болон тухайн бүс нутаг, орон нутгийн хэмжээнд мөрдөгдөх ерөнхий гэрээ байгуулах;

57.8.3. тухайн орон нутагт буюу энэ хуулийн 49.2-т заасан чиг үүргийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх;

57.8.4. захиалагч болон тендерт оролцогчдыг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

58 дугаар зүйл. Захиалагчид гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

58.1. Захиалагч тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзвэл тендерийн нээлтээс өмнө сонирхогч этгээд, тендерийн нээлтээс хойш оролцогч тус тус энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болно.

58.2. Захиалагчид гаргах гомдолд зөрчлийг нотлох баримтыг хавсаргана.

58.3. Захиалагч энэ хуулийн 30.1-д заасан шийдвэр гаргаснаас хойш гомдлыг захиалагч хүлээн авахгүй.

58.4. Захиалагч гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор гомдол гаргагчийн нэрийг дурдалгүйгээр бусад оролцогч, сонирхогч этгээдэд гомдлын агуулгыг цахим системээр мэдэгдэж, мэдэгдэлд гомдол хянан шийдвэрлэх талаар сонсох ажиллагаа хийх талаар Захиргааны ерөнхий хуулийн 27.3, 27.4-т заасан мэдээллийг тусгасан байна.

58.5. Оролцогч, сонирхогч этгээд энэ хуулийн 58.4-т заасан сонсох ажиллагаанд оролцоогүй бол гомдолд дурдагдсан асуудлаар цаашид гомдол гаргах эрхгүй.

58.6. Захиалагч гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрт гомдлыг хүлээж аваагүй бол түүний үндэслэл, гомдлыг хүлээн зөвшөөрсөн бол түүнийг барагдуулах арга хэмжээг тусгасан байна.

58.7. Нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс тендер шалгаруулалтыг зогсоолгүйгээр үргэлжлүүлэх шаардлагатай гэж захиалагч шийдвэрлэснээс бусад тохиолдолд гомдол ирснээс хойш захиалагч гэрээ байгуулах эрх олгож болохгүй.

58.8. Энэ хуулийн 58.7-д заасны дагуу тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэх шийдвэр гаргасан бол холбогдох үндэслэлийг тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхээс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө гомдол гаргагчид албан ёсоор мэдэгдэнэ.

59 дүгээр зүйл. Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх зөвлөл

59.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх зөвлөл (цаашид “зөвлөл” гэх) ажиллана.

59.2. Зөвлөл байнгын ажиллагаатай байх бөгөөд худалдан авах ажиллагаа, хууль эрх зүйн чиглэлээр мэргэшсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

59.3. Зөвлөлийн гишүүнд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим тус бүр 3 гишүүнийг олон нийтэд нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр нэр дэвшүүлнэ.

59.4. Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй холбоотойгоор Засгийн газар Нийтийн сонсголын тухай хуульд заасан томилгооны сонсгол хийж, гишүүдийг Ерөнхий сайд 5 жилийн хугацаагаар томилно. Зөвлөлийн гишүүнийг улираан томилохгүй.

59.5. Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар томилно. Зөвлөлийн даргаар улираан томилохгүй.

59.6. Зөвлөлийн гишүүнд гомдол хуваарилах, гомдол хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг сонгох журам нь урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд зөвлөлийн нийт гишүүдийн хурлаар батална.

59.7. Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын алба байна.

59.8. Зөвлөл, түүний ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, цалин урамшууллыг зохицуулах болон гишүүдийг томилох, чөлөөлөх журмыг Засгийн газар батална.

60 дугаар зүйл. Захиалагчийн шийдвэрт гомдол гаргах

60.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичиг өрсөлдөөн хязгаарласан тухай гомдлыг тендерийн нээлтээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө, оролцогч энэ хуулийн 30.1-д заасан болон бусад захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн тухай, эсхүл оролцогч захиалагч хуульд заасан хугацаанд шийдвэр гаргаагүй тухай гомдлыг тус тус ажлын 5 хоногийн дотор зөвлөлд гаргана.

60.2. Гомдол гаргах эрх бүхий оролцогчоос зөвлөлд гаргах гомдол нь тодорхой үндэслэл бүхий байх бөгөөд тендерийн баталгаа шаардсан тендер шалгаруулалтад холбогдох гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд тендерийн баталгаа хүчинтэй байхыг шаардана.

60.3. Захиалагч оролцогчийн ирүүлсэн тендерийн баталгаа шаардлага хангахгүй гэж шийдвэрлэсэнтэй холбогдох гомдол гаргах бол оролцогч энэ хуулийн 60.16-т зааснаар улсын орлого болгож болзошгүй мөнгөн хөрөнгийг Төрийн сангийн холбогдох дансанд байршуулна.

60.4. Зөвлөлийн дарга энэ хуулийн 60.2-т заасан шаардлагыг хангахгүй гомдлыг хүлээн авахаас татгалзаж буцаах ба зөвлөлөөс урьд нь шийдвэрлэж хариу өгсөн асуудлын хувьд шүүхэд хандах тухай мэдэгдэнэ.

60.5. Зөвлөл дараах тохиолдолд зөвлөлөөс гаргах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэл хугацаанд захиалагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх болон үйлдэл хийхгүй байхыг даалгаж болно:

60.5.1. гомдлыг хангах илүү үндэслэлтэй байгаа бол;

60.5.2. түдгэлзүүлээгүй, үйлдэл хийхгүй байхыг даалгаагүй тохиолдолд оролцогчид их хэмжээний хохирол учрахаар бол;

60.5.3. түдгэлзүүлэх, үйлдэл хийхгүй байхыг даалгах нь төрийн эрх бүхий байгууллага, захиалагч болон бусад оролцогчдод илтэд хохиролтой биш бол.

60.6. Энэ хуулийн 60.5-д зааснаар түдгэлзүүлсэн хугацаанд захиалагч шийдвэр гаргахад баримтлах энэ хуулийн 24.1-д заасан хугацаа тоолохыг зогсооно.

60.7. Зөвлөл гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлснээс хойш тухайн тендер шалгаруулалтад холбоотой цахим системд байршсан бүх баримт бичиг, мэдээлэлтэй танилцах эрхтэй бөгөөд баримт бичиг, мэдээллийн бүрэн, үнэн зөв байдлыг захиалагч хариуцна.

60.8. Зөвлөл шаардлагатай гэж үзвэл тендер шалгаруулалтад холбогдох баримт бичиг, материалын эх хувийг ирүүлэхийг шаардах ба захиалагч шаардсан хугацаанд авч ирэх үүрэг хүлээнэ.

60.9. Зөвлөл энэ хуулийн 60.1-д заасан гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

60.10. Гомдлыг хянан шийдвэрлэхээр хуваарилагдсан зөвлөлийн гишүүд гомдлыг хянан хэлэлцэхэд захиалагч, гомдол гаргагч, бусад сонирхогч этгээд, оролцогчид болон бусад төрийн эрх бүхий бусад байгууллагын төлөөлөл

оролцуулах шаардлагатай гэж үзсэн бол маргаан хянан шийдвэрлэх холбогдох талуудаас бичгээр тайлбар авах, эсхүл биечлэн оролцуулж болно.

60.11. Гомдлыг хянан шийдвэрлэхээр хуваарилагдсан зөвлөлийн гишүүд шаардлагатай гэж үзвэл гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай асуудлаар тухайн салбарын төрийн эрх бүхий байгууллагаас дүгнэлт гаргуулж болно.

60.12. Зөвлөл оролцогчийг шаардлага хангасан эсэх, тендерийг хянан үзсэн, үнэлсэн эсэх асуудлаар зөвхөн гомдолд дурдсан үндэслэлийн хүрээнд хянаана.

60.13. Энэ хуулийн 60.12-т зааснаар гомдлын хүрээнд хянах нь захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулахад энэ хуульд заасан журмыг баримталсан эсэхийг хянахыг хязгаарлах үндэслэл болохгүй.

60.14. Зөвлөл гомдлыг хянан хэлэлцээд захиалагч энэ хуулийг зөрчсөн гэж үзвэл дараах шийдвэр гаргах бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна:

60.14.1. захиалагчийн шийдвэр буюу үйлдлийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, өөрчлөлт оруулах;

60.14.2. тухайн асуудалд хуулийн ямар заалт хэрэглэхийг заах;

60.14.3. зөрчлийг арилгасны үндсэн дээр тендер шалгаруулалтыг явуулахыг захиалагчаас шаардах.

60.15. Зөвлөл гомдол хянан шийдвэрлэх явцад илэрсэн зөрчлийн талаар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлж болно.

60.16. Зөвлөл гомдлыг хянан шийдвэрлээд бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн бол 20 тэрбум төгрөг хүртэлх төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 20 хүртэл сая төгрөгийг, 20-100 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 40 сая төгрөгийг, 100 тэрбумаас дээш төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн баталгааны 60 сая төгрөгийг тус тус улсын орлого болгоно.

60.17. Зөвлөл гомдол хянан шийдвэрлэх үйл явцын мэдээллийг улирал тутамд цахим системд олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

61 дүгээр зүйл. Шүүхэд гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

61.1. Зөвлөл энэ хуулийн 60.6-д заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрсөн тухай гомдлыг шүүхэд гаргаж болно.

61.2. Худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагч энэ хуулийн 56.11-д заасан хугацааны дотор шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тухай гомдлыг шүүхэд гаргаж болно.

61.3. Захиалагч гэрээ байгуулснаас хойш гомдлыг зөвхөн шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ.

61.4. Шүүх энэ хуулийн 60.5-т зааснаас бусад тохиолдолд зөвлөлийн, захиалагчийн, эсхүл худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн шийдвэрийг түдгэлзүүлэхийг хориглоно.

61.5. Шүүх захиалагчийг энэ хуулийн 31.1-т заасан хугацааг зөрчиж, эсхүл энэ хуулийн 60.5-т заасан шийдвэр гаргасан хугацаанд гэрээ байгуулсныг тогтоосон бол улсын төсвөөс санхүүждэггүй захиалагчийг гэрээний үнийн дүнгийн 5 хүртэл хувийг улсын төсөвт төлүүлэхээр шийдвэрлэнэ.

62 дугаар зүйл. Хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх

62.1. Худалдан авах ажиллагаанд оролцох ажилтан, албан тушаалтан энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол төрийн албан хаагчид

Төрийн албаны тухай хуулийн 48.1¹, хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн² 123.2-т тус тус зааснаар хариуцлага хүлээлгэнэ.

62.2. Энэ хуулийн 62.1-т зааснаар хариуцлага хүлээлгэсэн нь ажилтан, албан тушаалтанд энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хуульд зааснаар хариуцлага хүлээлгэх, хохирол нөхөн төлүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

63 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

63.1. Энэ хуулийг 2022 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

¹ Төрийн албаны тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.

² 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.